



СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/04

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын
Сонгуулийн
ерөнхий хороо

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ ДУГААР 2023/04

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Д.Бат-Эрдэнэ

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн дарга

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн тэргүүн

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

З.Бадмаараг

Сэтгүүлч

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан
тул олшруулахыг хориглоно.



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА



05

01 СОНГУУЛЬД
СУРАЛЦАХУЙ



11

02 ДУГААРЫН
ЗОЧИН



17

03 ХУУЛЬ ТОГТООМЖ



25

04 СУДАЛГАА



33

05 ЦАХИМ СИСТЕМ



35

06 СОНГУУЛИЙН ТҮҮХ



39

07 СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛД



43

08 ХАРИУЦЛАГАТАЙ
СОНГОГЧ



49

09 СОНГУУЛЬ ДЭЛХИЙ
ДАХИНД



55

10 СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛ КЛУБ





01

СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

- Та, бид юуны учир, хэний төлөө саналаа өгдөг вэ?

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


5

ТА, БИД ЮУНЫ УЧИР, ХЭНИЙ ТӨЛӨӨ САНАЛАА ӨГДӨГ ВЭ?*



БЯРААГИЙН ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш,
Гавьяат хуульч, доктор, профессор



Аливааг эцсийн зорилго, үр дүнг нь бодож л шийддэг шүү дээ. Сонгуульд саналаа өгнө гэдэг чинь эцсийн шийдвэр. Энэ чинь ёслол биш, бөөн хариуцлага.

Та хэнд саналаа өгчихөөд ирэв дээ гэж хөршийгөө асуухад, нөгөө хөрш нь:

- «Цэг гэм, нууц!» гэснээ зөөлөрч өөртөө таалагдсан хүнийхээ өмнөх

дугаарыг л дугуйлж таараа шүү дээ гэнэ. Иймэрхүү яриа айл ч хөршийнхний хооронд гарч л байдаг. "Таалагдсан хүн" гэж хэн бэ? Түүнийг яагаад юуны төлөө сонгодог билээ гэж лавшруулан бодвол юу хэлж болохсон билээ?!

Номын эхний бүлэгт, бас энэ бүлгийн холбогдох зүйлүүдэд ард түмэн засгаа мэдэх бүрэн эрхт байдлынхаа үндсэн дээр өөрийгөө төлөөлүүлэн засаг төрийн жолоо бариулан өөрсдөдөө үйлчлүүлэхийн төлөө сонгууль хийдэг тухай өгүүлсэн. Харин чухам хэнийг юуны учир сонговол дээр вэ? Сонгогдсон төлөөлөгч юу хийдэг вэ? гэдэг тухайд "сайн хүнийг", "сайн хөтөлбөр"-ийг гэхчилэн ерөнхийд нь дурдсан. Энэ тухайд ихэд эргэцүүлэн бодох учиртай. Улс орон маань сайн засагтай, улс төр тогтвортой, ухаалаг хууль журамтай, урам (мөнгө биш) өгдөг зүтгэлтнүүдтэй баймааж урагшлан хөгжинө.

Манай орон парламентын буюу

хамтын төлөөлөх байгууллагын засагтай, тэр нь та бидний сонгосон гишүүн гэх төрийн зүтгэлтнүүдээс бүрдэж, тэдний баталсан хууль тогтоомжоор улсаа жолооддог. Ийм л байгууллагыг сонгохыг УИХ-ын сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүрэгт бол ИТХ-ын сонгууль гэж байгаа юм. Үндсэн хуульд заасныг дахин нэг лавлан харъя!




Монгол Улсын Үндсэн хуулийн хорьдугаар зүйлээс:

"Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэжээ.

* Б.Чимид. Сонгуульд суралцахуй, УБ, 2008, 62-69 дэх тал.

Хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байх нь ээ. Энэ бол хууль гаргаад («цаас үйлдвэрлээд») орхичихдог гэсэн үг биш, харин иргэдийнхээ ашиг сонирхол, эх орныхоо хувь заяаны төлөө бүх нийтээр дагаж мөрдөх дээд хүчинтэй баримт бичиг гаргана; Түүнийхээ биелэлтийг зогсоо зайгүй хянаж, хангуулах замаар тэр хуулиараа улсаа жолоодно гэсэн их үйл хэрэг. Үүний тулд Үндсэн хуулиар түүнд онцгой бүрэн эрх олгосон байдаг.



ХЭНИЙ ТӨЛӨӨ ВЭ? ШИЛЭХИЙН ТУХАЙД

Их л юм хэлж болно доо. Шударга ариун зан төлөвтэй, мэдлэг, туршлагатай, олон улсын түвшинд сэтгэдэг, ажилсаг чанар гээд л тал талаас нь харна. Зарчмын гэмээр хэдэн шалгуур бий.

- Үндсэн хуульд УИХ-ын гишүүнээр Монгол Улсын 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно гэсэн үндсэн шаардлага (болзол) бий. 18 нас хүрээд сонгох эрх эдэлдэг бол сонгогдоход 25-аас доошгүй настай байх гэдэг нь нийгэм-улс төрийн тухай зохих мэдлэг, амьдралын туршлагатай болсон байх шаардлагыг илэрхийлнэ. Энэ бол зөвхөн нэг компанийн удирдлагад байсан гэсэн үг ч биш засаг төрийн тухай мэдлэг туршлагыг бодолцохыг багтаана.
- Нэр дэвшигчид тавих шаардлага (болзол) бол гишүүн байхад нэг адил хамаарна. Нэр дэвшигч нь бусдад ("төр, хувь хүн, хуулийн этгээдэд") шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын болон гэрээгээр хүлээсэн, хугацаа хэтэрсэн өргүй байх зэрэг тусгай шаардлагыг заасан байна.

Нэр дэвшигчдэд хориглосон зүйл шаардлага нь тухайн үедээ хэрэглэгдэхээс бус сонгогдсон хойно "юу ч хийсэн халдашгүй" тул хамаарахгүй гэж андуурч болохгүй. "Өртэй хүн өөдөлдөггүй, өттэй мал таргалдаггүй" гэдэг шиг, дээр

дурдсан нь тухайн гишүүнд тавигдах хууль зүйн шаардлага мөн бөгөөд "ашиг сонирхлын зөрчилгүй" байх явдалтай шууд холбоотой. Өртэй гишүүн "татварын өршөөл" мэтийн хууль гаргах сонирхолд автахыг хэн ч үгүйсгэхгүй. Энэ мэтээс үзвэл сонгохдоо гишүүн болчихоод улс, нийтийн төлөө юу, өөрийн төлөө ажиллах хүн үү? гэдгийг л бодолцож, хянаж хандах нь хууль ёсны ба зүй ёсны юм. Биеийн байцаалт, хөрөнгийн мэдүүлэг, өргүйн тодорхойлолт авдаг нь учиртай. 20 хоног, 2, 3-хан сар туршлага үзэж дамжаанд суучихаад олон дээд сургууль төгссөн гэх, хөрөнгөө дутуу мэдээлэх зэрэг нь уг хүний чансааг харуулна.

ХУУЛЬ ЗҮЙНХЭЭС ГАДНА УЛС ТӨР, ЁС СУРТАХУУНЫ ШААРДЛАГА Ч БИЙ

Сонгууль бол дарангуйлагч засгийн үе дэх хаан, хан, засаг ноёдыг нас барахаар хүү нь, хүүгүй бол ач нь гэхчилэн угсаа залгаж засаг эзэрхэх ёсыг халсны дүнд тогтсоныг дээр цухайлгасан. Энэхүү ёс нь хөрөнгө өмчлөх, аж ахуй эрхэлж, орон гэр, удам угсаагаа авч явахад одоо ч хэрэглэн буй эртний уламжлал юм. Гэвч ард түмний өмнөөс сонгуулиар засаг барихад энэ ёс хэрхэвч тохирохгүй тул нийтээр цээрлэдэг болжээ. «Генералийн хүү, орон нутгийн захирагчийн хүү, депутатын хүү, эсвэл Ерөнхийлөгчийн хүү эцгээ залгамжлах явдлыг өрнөдөд хүлээн зөвшөөрөхөө больжээ. Гэвч банкны захирлын, үйлдвэрийн эзний хүү, эсвэл худалдаачны хүү гэх мэт эцгээ залгамжлах явдлыг (тэр ажлыг нь -Б.Ч) бүрэн хүлээн зөвшөөрч байна» гэж Францын нэрт судлаач бичжээ.¹ Улс төрийн засгаас хувийн аж ахуй тусдаа заагтай, засагтай байдаг нь үүнээс ойлгомжтой.

¹ Б.Чимид. Сонгуульд суралцахуй, УБ, 2008, 62-69 дэх тал.



Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлээс:

"1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ" гэжээ.

Энэ тухай Үндсэн хуульд 18 төрлийн асуудлыг нэрлэж заасан байна. Тэдгээр нь "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах"; "Ерөнхийлөгч ба УИХ, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах"; "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах"; "хууль, УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах" зэрэг улс орны хувь заяатай шууд холбоо бүхий амин чухал асуудлууд юм.

Ийм онц чухал байгууллагыг сонгож бүрдүүлнэ гэдэг зүгээр нэг "таалагдсан хүнд" саналаа өгөх төдий хэрэг биш, нийгмийн асар их үүрэг хариуцлага юм.

Гэтэл Монголд нам, эвсэл дээдсийг нас бармагц төрөл саданг нь шууд залгамжлахаар нэр дэвшүүлж дэмжих хандлага үзэгдэнэ. Ийм хандлага лавширвал гэр бүлсэг байдалд хүргэж хөрөнгөлөг цөөнх бүлгийн ноёрхол (олигархи) бий болоход дөхөм болно. Энэ мэтийг мэдсээр байж тийм хүмүүсийг сонгочихоод "олигархиуд² гэж хашгичиж суухын хэрэг юун. Саналаа өгөхдөө л зөв шийдчихвэл барав гэмээр байгаа биз!

Угсаа залгамжлахаас болгоомжлох зарчмын санааг, гуйвуулан хэрэглэж болохгүй. Боловсролтой, сурвалжит гэр бүлд өсөж хүмүүжээд өндөр мэргэжил эзэмшиж үр бүтээлээрээ шалгарч товойсон хүмүүсийг нийтэд нь хялайн гадуурхваас томоохон хэлмэгдүүлэлд хүргэж, нийгмийн оюуны чадавхид үлэмж гарз хохирол учруулдгийг хэлмэгдүүллийн түүх харуулсан. Тийм болохоор засгийн халуун суудлыг шууд залгамжлуулахыг цээрлэж, харин товойн тодорсон үед тохирох албанаа тохоон олны тусын тулд мэдлэг чадварыг нь ашиглах явдал зүйн хэрэг биз ээ.

2 "Олигархи" гэдэг /үг нь "Oligarchia"-цөөнхийн засаг гэсэн утгатай Грек гаралтай үг/ нь улс төр, эдийн засагт хөрөнгөлөг явцуу бүлгийн ноёрхол тогтсоныг хэлнэ.



ДЭМЖСЭН ХҮНЭЭРЭЭ ЮУ ХИЙЛГЭХ ГЭЖ СОНГОДОГ ВЭ?

"SBN" телевизийн «Мөрөөдлийн парламент» нэвтрүүлгийн 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 22 цагийн үзүүлбэрээр сурвалжлагч, үзэгч хоёр ярилцаж байна аа! УИХ-ын сонгуулийн 65 дугаар тойргийн нэгэн сонгогч ("Ард Аюушийн гудамнаа оршин суугч" гэх) "нэг юм ярья" гээд:

- Шадар сайд сонгогдох гээд л Б-тэй хөлхөлдөөд, элдвийг

амлаад явсан. Календарь, том шаазан хоёр л өгсөн "Өөр юмгүй, үзэгдэхээ ч больж. Хог нохой хоёр болохоо байлаа. «Хотон дотроо үнсээрээ амьсгалаад гялгар уутаар нүүрээ таглуулаад л явж байна». Өөрөөсөө гаргадагсанжуу, улсаас гаргадаг сан уу мөнгөөр тусалж хогноос салгаж өгөөч гэх утгаар яриу. Нэвтрүүлэг хөтлөгч дэмжиж байгаа бололтой хариу илэрхийлэв (үг, аялга зэргээрээ шүү).

Иймэрхүү өнгөтэй үг яриа ганц энэ биш билээ. Ялангуяа УИХ-ын гишүүдэд төсвөөс 5; 10; 250 саяын хөрөнгө мөнгө өгснөөс хойш сонгогч сонгогдогч хоёр засаг төрийн бус, эд мөнгөний харилцаанд автаж, өндөр дээд УИХ-ын эрхэм гишүүд маань ч орон сууцны цонх хаалга сольж, шал дээвэр битүүлэх, сургууль эмнэлгийн засвар хийлгэж, сандал, ширээ ойр зуурын хөгжим цахим хэрэгсэл өгч аргалдаг, өрд баригдсан нэгэн болон "жигжгэрч" байна даа! Энэ бүхэн сум, анхан шатны нэгжийн дарга эрхэлж, хоршоо пүүсийн засварчны л эрхэлдэг өдөр тутмын ажил шүү дээ!

Тэгээд гишүүнийг юу хийлгэх гэж сонгодог вэ? гэвэл юутай ч өөрт унах ашгийн төлөө зүтгэж, үйлдвэр, худалдаа, хөрөнгийн гүйлгээ эрхэлж,



мөнгө босгох зэргийн аж ахуйн ажил ч биш;

Жилдээ нийлээд 100 хоног үргэлжилдэг чуулганд алдаг оног сууж товчлуур дараад бусад үед гадаад, дотоодод аялж, алба амины ажил хөөцөлдөхийг ч бас хэлэхгүй.

Харин УИХ-д (зөвхөн чуулганд бус) түмэн биднийгээ тасралтгүй шууд төлөөлөн байнга сууж улс төрийн бодлогын хэмжүүр болсон хуулийн төсөл хянаж, чиглүүлэн боловсруулж, санаачлан хэлэлцүүлж биелэлтийг хянаж, сонгогчдынхоо нийтлэг хүсэл зоригийг хуулиар дамжуулан хэрэгжүүлж ажилладаг зүтгэлтэн билээ. Үүнийг тодруулахын тулд гишүүнд олгосон "бүрэн эрх" буюу "мандат"-ын хэв шинжийг мэдэх хэрэгтэй дээ!

Мэдвэл хаана, хаанаасаа зөв үнэлэмжтэй хандана.

Парламентын гишүүний бүрэн эрхийг хууль зүйн шинж байдлаар нь:

- Захирагдмал (императив) мандаттай;
- Чөлөөт мандаттай гэж ялган үздэг.

Захирагдмал мандаттай гэж юуг хэлэх вэ? Хэрэв парламентын гишүүн нь:

- УИХ-д суухдаа гагцхүү тойргийнхоо сонгогчдын захиа даалгаврыг биелүүлэх үүрэгтэй;
- тийм учир тойргийн сонгогчдын буюу орон нутгийн иргэдийн бүрэн эрхшээлд байдаг;
- баталж өгсөн захиа даалгаврыг нь биелүүлэхгүй бол сонгогчид дуртай цагтаа огцруулдаг зарчимтай бол захирагдмал мандаттай гэдэг. Энэ бол нэг тойрогт явцуурна гэсэн үг боловч хоёр танхимтай парламентын дээд танхимын гишүүний бүрэн эрхийн шинж мөн.

Социалист маягийн парламентын депутатуудын хэв шинж ийм байсныг дээр 1 дүгээр бүлэг (1.2.3)-т Монголынхоо жишээн дээр

тайлсныг үзээрэй. Тэр бол байнгын бус, тойрогтоо өөр ажил эрхлэгчдээс бүрдсэн парламенттай байсных юм.

Монгол Улс 1992 оноос байнгын парламенттай болсон учир бүрэлдэхүүн нь өөр ажил "эрхлэхийн зэрэгцээгээр биш" өмнөх ажил албанаасаа чөлөөлөгдөж зөвхөн гишүүний алба хаших болсон юм.



Монгол Улсын Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлээс:

«Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт ажлаас нь хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэжээ./2000 оны нэмэлт өөрчлөлт/

Өдгөө эрх мэдэл хуваарилах сонгодог онолын ёсоор парламентын гишүүний мандат (бүрэн эрх) нь гүйцэтгэх эрх мэдлийн болон мэргэжлийн ямар ч үйл ажиллагаатай хавсрахыг цээрлэдэг. Гишүүний байнгын цорын ганц үүрэг бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал мөн. Ингэж дагнуулах нь "зөөлөн суудал"-д залах гэж бус уг ажил нь («хатуу хоол») нүсэр, оюуны хөдөлмөр зарцуулалт ихтэй сая хүний хувь заяанд холбогдсон өндөр хариуцлагатай болоход оршино.

УИХ нь **тасралтгүй** ажиллаж, хууль тогтоох замаар улс орноо өдөр тутам жолоодох болсныг **парламентат ёс гэж** байгаа юм. Засаг завсарладаггүй, чуулган завсарлах нь УИХ завсарласан гэсэн үг биш, хянан шалгах, боловсруулах гээд улам их ажил ундарна. Энэ ёс их хөгжсөн оронд "парламентын амралт" ("каникул") гэж 30, 40 хоног

байхаас чуулган завсарлах нэрээр жилдээ 260 хоног тарж явахыг хэлдэггүй бололтой.

Парламентат ёсны чухал шинж нь **чөлөөт мандат бүхий** байнгын гишүүнээс бүрддэг явдал мөн. Үүнд олон шалтгаан бий.

Чөлөөт мандаттай гэдэг нь гишүүн хүн зөвхөн тойргоос хамаарч, зөвхөн түүний төлөө бус харин улс нийтийн ашиг сонирхлыг хангахын төлөө улсын хууль тогтоож ажиллах эрх үүрэгтэй гэсэн үг.



Монгол Улсын Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлээс:

«1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална» гэжээ.

Энэ үндэслэлийг тойргийн сонгогчдын, ер нь ард нийтийн хяналтаас гадуур дархлагдсан хэмээн хэтрүүлэн ойлгож бас болохгүй. Харин тойргийн сонгогчдын хэрэгцээ сонирхлыг улс нийтийнхтэй нийцүүлэн харгалзах ёстой юм.

Сонгогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн хувьд хэний ч эрэлт хүсэлтийг сонсож хуулийн дагуу шийдвэрлэхэд нь дөхөм үзүүлэх, улсын асуудал мөн байвал шууд шийдвэрлүүлэхээр хууль санаачлан УИХ-д оруулан хэлэлцүүлэх онцгой эрх мэдэлтэй.

- Энэ бол эрх,
- энэ бол үүрэг,
- нийтэд нь бүрэн эрх гэдэг юм.

Хууль бол улс нийтийнх байдгийн учир тэр. Хууль тогтоогч нь гишүүн бөгөөд тийм л ажлыг гүйцэтгүүлэх гэж түүнийг сонгодог билээ.



1



ЦИНН
СҮНІТ АНЫСАН



02

ДУГААРЫН ЗОЧИН

- П.Дэлгэрнаран: Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намуудтай хамтран улс төрийн намын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

11

П.ДЭЛГЭРНАРАН:

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО УЛС ТӨРИЙН НАМУУДАЙ ХАМТРАН УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийгдэж буй бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнарантай ярилцлаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэн баталлаа. Энэ хуулиудын онцлог зохицуулалтаас танилцуулна уу.

Улсын Их Хурлын сонгуулийг хосолсон тогтолцоогоор зохион байгуулах, Гадаад улсад байгаа иргэдээс саналавах, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод,

хяналттай байдлыг нэмэгдүүлэх, сонгуулийн зардлыг бууруулах зэрэг чиглэлээр 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Мөн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Энэхүү хууль нь Монгол Улсын Үндсэн Хуулийн 191 дүгээр зүйлд заасны дагуу нам улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, намын

дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх, бодлогын нам болж хөгжихөд нь төрөөс шууд болон шууд бус байдлаар дэмжлэг үзүүлэх зэрэг зарчмын олон өөрчлөлтийг хуульчилсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, төрөөс үзүүлэх шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх, намын дотоод зохион байгуулалт бүтэцтэй холбоотой зохион байгуулалтыг 2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа дагах мөрдөхөөр хуульчилсан.

Дээрх хоёр хууль нь үзэл баримтлал, зохицуулалтын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шинэ тутам хуульчлагдсан тул хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэлийг бүрэн хангах, сонгогч, иргэд, олон нийтэд хуулийн тогтоомжид оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл, ойлголт өгөх уулзалт сургалтыг өргөн хэмжээнд зохион байгуулах, шаардлагатай хүний болон бусад нөөцийг бүрдүүлэх, бэхжүүлэх нь нэн тэргүүнд зохион байгуулах шаардлагатай үйл ажиллагаа юм. Иймд 2023 оны А/40 дүгээр захирамжаар “Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г баталсан. Уг төлөвлөгөөнд үндсэн 5 чиглэлийн нийт 27 арга хэмжээ авч ажиллахаар тусгасан.

Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд ямар ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлж байна вэ?

Сонгуулийн тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, сонгогчдод ойлгомжтой, хүртээмжтэй

сонгуулийн сурталчилгааны эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан “нэгдсэн самбар” ашиглахаар хуульчилсан. Нэгдсэн самбар нь суманд 2, аймгийн төвийн суманд 5, нийслэлийн хороонд 4 хүртэл хэмжээтэй байх бөгөөд уг самбарыг сум, дүүргийн Засаг дарга бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна.

Нэгдсэн самбарын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвд хүсэлт гаргаж хийлгүүлсэн бөгөөд уг тооцооллыг Сангийн яам болон 330 сум, нийслэлийн 9 дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт 2023 оны 7, 8, 11 дүгээр саруудад буюу нийт 3 удаа зөвлөмж хүргүүлсэн.

мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн хөгжүүлж байна. Энэхүү систем нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад үүсдэг олон төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимаар авах, бүрдүүлэх боломжтой юм. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-mongolia” цахим үйлчилгээний төрөлд нэмэгдсэн бөгөөд 2023 оны орон нутгийн нөхөн болон дахин сонгуулиар системийн туршилтыг амжилттай зохион байгуулсан. Мөн бие даан нэр дэвшигчдийн гарын үсэг зуруулах үйл ажиллагааг “e-mongolia” системээр дамжуулан цахимаар зохион байгуулах техникийн шийдлийг боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

“

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд сонгуулийн сурталчилгааны “НЭГДСЭН САМБАР” ашиглахаар хуульчилсан

”

Сонгуулийн тогтолцоо болон Улсын Их Хурлын гишүүдийн тооны өөрчлөлттэй холбоотойгоор сонгуульд нэр дэвшигчдийн тоо нэмэгдэнэ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар нэр дэвшигч 9-өөс 11 төрлийн баримт, лавлагааг бүрдүүлдэг. Иймд нэр дэвшигчдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, холбогдох лавлагаа, тодорхойлолтыг цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан” цахим системийг Нийтийн

оргуулсантай холбоотойгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2 дахь жилдээ зохион байгуулж буй 18-25 насны сонгогчдод сонгуулийн ач холбогдол, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны онцлог, сонгуульд хариуцлагатай оролцох тухай мэдлэг олгох “Хариуцлагатай сонгогч” албан бус, үндэсний хөтөлбөрийн агуулгад нэмэлт, өөрчлөлт оруулан сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 110 сургагч

“

**Монгол
улсын их
хурлын 2024
оны ээлжит
сонгуулиар
гадаад
улсад байгаа
иргэдээс
санал авна**

багш бэлтгэсэн бөгөөд одоогоор 18-25 насны нийт 4450 сонгогчид дээрх чиглэлээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулаад байна.

Улс төрийн намын тухай хуульд зааснаар төрөөс намд үзүүлэх шууд дэмжлэгийг 2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнг үндэслэн тооцож, улмаар хуульд заасан шаардлага хангасан намд 2025 оны нэгдүгээр сараас эхлэн энэхүү шууд дэмжлэгийг үзүүлж эхэлнэ. Шууд бус дэмжлэг буюу намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг сонгуулийн бус жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах зохицуулалтын хэрэгжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газруудад үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах болон бусад шаардлагатай бэлтгэл хангах асуудлаар зөвлөмж хүргүүлэх ажлыг төлөвлөөд байна.

Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хороо Улсын дээд шүүхтэй хамтран “намын дарга, дүрэм, хөрөнгө түүний өөрчлөлтийн бүртгүүлэх, намыг идэвхгүйд тооцох баримт бүрдүүлэх журам”-ыг, Сангийн яамтай хамтран “Намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журам”-ыг тус тус батална. Үндсэн төлөвлөгөөний дагуу журмын төсөл боловсруулах, бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын хэсгийг Хорооны нарийн бичгийн дарга ахлан ажиллаж байна.

Сонгуулийн Ерөнхий хороо Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссоос дээрх чиглэлээр мэдээлэл авах, туршлага

судлах уулзалт-сургалтыг Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2023 оны 10 дугаар сарын 23-наас 26-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулсан. Энэхүү туршлага судлах уулзалт-сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын төлөөлөл, Улсын Дээд шүүхийн төлөөлөл оролцлоо.

Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, улс төрийн намыг дотоод ардчилалтай, хяналттай, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг улс төрийн нам, олон нийтэд тайлбарлан таниулах, хуулийг нэг мөр, зөв ойлгуулах хэрэгцээ шаардлагад үндэслэн уг хуулийн хэрэглээний гарын авлага боловсруулах асуудлаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрт хандсан. Уг хүсэлтийн дагуу энэ онд багтаан гарын авлага боловсруулах ажил эхлээд байна. Энэхүү гарын авлага нь цаашид уг хуулийг улс төрийн нам, олон нийтэд тайлбарлан таниулах сургалт, үйл ажиллагааны үндсэн хэрэглэгдэхүүн болох бөгөөд хуулийн үндсэн зорилго, үзэл баримтлалын талаар улс төрийн нам, олон нийт үнэн зөв, нэг мөр ойлголттой болсноор хуулийн хэрэгжилтийг талууд бүрэн хангах боломж бүрдэнэ.

Улс төрийн намын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх дээрх сургалтыг хуваарийн дагуу 11 дүгээр сард багтаан зохион байгуулж дуусгалаа. 12 дугаар сард батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах талаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бүх улс төрийн намын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Уг уулзалтаар Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилгыг тодорхойлсон

бодлогын баримт бичиг буюу намын хөтөлбөрийг хуульд Монгол Улсын Үндсэн хууль болон улс төрийн намын тухай хуульд заасны дагуу боловсруулах, 2024 оны ээлжит сонгуулиас өмнө иргэд сонгогчид нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэх асуудлаар зөвлөмж хүргүүлнэ.

Хууль тогтоомж сурталчлах, мэдээлэл өгөх сургалт, уулзалт зохион байгуулах ажил үргэлжилж байна уу?

Сонгуулийн хууль тогтоомж болон Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах зорилгоор 2023 оны А/39 дүгээр захирамжаар үндсэн 5 сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан.

Дээрх батлагдсан хөтөлбөрийн дагуу бүх шатны сонгуулийн хороодод ажиллах төрийн албан хаагчид, улс төрийн нам түүний гишүүд, дэмжигчид, иргэд сонгогчдод дээрх хоёр хуулийг тайлбарлан таниулах, мэдээлэл өгөх сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хуваарь гарган зохион байгуулж ажиллалаа.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран 2023 оны 08 дугаар сарын 25-наас 29-ний өдрийн хороонд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад, 2023 оны 09 дүгээр сарын 17-ноос 22-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгуудад,

Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад, 2023 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Дархан-Уул аймагт,

2023 оны 10 дугаар сард Өмнөговь, Дундговь, Төв аймаг, нийслэлийн 9 дүүрэгт, 11-р сард Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Завхан, Архангай,

Хөвсгөл аймагт мэдээлэл өгөх уулзалт, сургалтыг зохион байгуулж дууслаа.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах ярилцлага, хөтөлбөрт оролцох чиглэлээр Монголын үндэсний радиотой хамтран “Сонгуулийн боловсрол” радиогийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэн нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Мөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач, сэтгүүлч бэлтгэх зорилготойгоор Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдсан “Сонгуулийн боловсрол клуб”-ээр дамжуулан дээрх 2 хуулийн талаарх онцлог өөрчлөлт, үзэл баримтлалын талаар сэтгүүлч, судлаачдад мэдээлэл өгөх уулзалт-сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, судалгааг тогтмол сонгогчдод хүргэх зорилго бүхий улирал тутмын “Сонгуулийн боловсрол” сэтгүүлийн 2023 оны 03 дугаарт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон онцлог зохицуулалтын талаар мэдээлэл бэлтгэн цаасан болон цахим хэлбэрээр сонгогчдод түгээх ажлыг зохион байгуулж байна. Мөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох зорилго бүхий “Сонгогчийн ном” эмхэтгэлийг хэвлүүлэн сонгогчдод цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлэх, цахим номын сан үүсгэх ажлыг зохион байгуулж байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар Сонгуулийн ерөнхий хороонд энэ чиглэлийн хүний нөөц бүрдүүлэх, чадавхжуулах

шаардлага бий болсон. Энэ ажлын хүрээнд юу хийж байна вэ?

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг хуулийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан бөгөөд уг чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийн нэгж байгуулах, Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурлаар тогтоолгох асуудлаар санал, дүгнэлтээ бэлтгэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж, шийдвэрлэсэн. Мөн Төрийн албаны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу шинээр нэмэгдэх орон тоо бүрээр албан тушаалын тодорхойлолт батлуулах, зарлах зэрэг ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намуудтай хамтарч ажиллах зайлшгүй шаардлагатай болсон. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад төрөөс улс төрийн намуудад шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх зохицуулалт орсон. Тиймээс Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намуудад энэ чиглэлээр арга зүйн зөвлөмж өгч, хуулийг хэрэгжүүлж ажиллана.

Баярлалаа.

Election Management Capacity Building Program

Supporting the Effective Implementation of Gender-Sensitive Legislation in Mongolia

October 23-26, 2023 Seoul, Republic of Korea

A WEB



KOICA



UHH MN
CHINTAAH ICAH





03

ХУУЛЬ ТОГТООМЖ

- Бүгд Найрамдах Солонгос Улсын үндэсний сонгуулийн комиссоос туршлага судлах, мэдээлэл авах уулзалт-сургалтад оролцлоо

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

17

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ҮНДЭСНИЙ СОНГУУЛИЙН КОМИССООС ТУРШЛАГА СУДЛАХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ УУЛЗАЛТ-СУРГАЛТАД ОРОЛЦЛОО

Д.Бат-Эрдэнэ

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн дарга

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Сонгуулийн Ерөнхий хороо нь эдгээр хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, шаардлагатай зохион байгуулалтын нэгж, бүтэц, орон тоо, албан хаагчдын чиг үүргийг оновчтой тодорхойлох, холбогдох маягтуудыг батлахын тулд ижил төстэй улсын Сонгуулийн байгууллагын чиг үүрэг, туршлага судлах, мэдээлэл авах хэрэгцээ үүссэн. Үүнтэй холбоотойгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн дэмжлэгтэйгээр Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо, БНСУ-ын

Үндэсний сонгуулийн комисс, Улсын Дээд шүүх, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран 2023 оны 10 дугаар сарын 22-ноос 27-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод туршлага судлах, мэдээлэл авах уулзалт-сургалтыг амжилттай зохион байгууллаа.



ЗОРИЛГО:

Сонгуулийн Ерөнхий хороо БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссоос жендэрийн мэдрэмжтэй хуулийн хэрэгжилтийг дэмжсэн мэдээлэл авах, туршлага судлах уулзалт-сургалтыг зохион байгуулснаар Монгол улсад Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

болон Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэг мөр, зөв ойлгож, хэрэгжилтийг бүрэн хангах, шаардлагатай зохион байгуулалтын нэгж, бүтэц, орон тоо, албан хаагчдын чиг үүргийг оновчтой тодорхойлох, холбогдох маягтуудыг боловсруулахад мэдлэг, мэдээлэл, арга зүйгээр хангахад оршино.



ЗОРИЛТ:

- БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссын эрх, үүрэг, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны туршлага, сургамжийг судлах,




- БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссоос намын бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэхдээ жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангадаг туршлагыг судлах,
- БНСУ-ын Үндэсний сонгуулийн хорооны намын бүртгэл, хяналтын хэлтсийн үйл ажиллагаа, тайлан, маягыг судлах,
- БНСУ-ын Солонгосын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Хүрээлэн (KWDI) байгууллагаас улс төрийн шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог хангах туршлага судлах,

БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссын бүтэц, чиг үүрэг:

БНСУ-ын Үндэсний Сонгуулийн комисс нь сонгууль, ард нийтийн санал асуулгыг шударгаар явуулах, улс төрийн намын бүртгэл, санхүүжилтийн үйл ажиллагааг хариуцах, түүнд хяналт тавих сонгуулийн хороодын зохион байгуулалт, нэгдсэн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий бие даасан, хараат бус байгууллага юм. Үндэсний сонгуулийн комиссын эрх зүйн байдлыг 1987 онд баталсан Сонгуулийн комиссын тухай хуулиар тодорхойлогддог бөгөөд уг хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндэсний сонгуулийн комисс нь нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 3 гишүүнийг Ерөнхийлөгч, 3 гишүүнийг Үндэсний ассамблей, 3 гишүүнийг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор нээлттэй сонголт явуулж, парламент 6 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар томилдог.

БНСУ-ын Үндэсний Сонгуулийн комиссын бүтэц, зохион байгуулалтын хувьд засаг захиргааны нэгжийн бүтцийг үндэслэн байгуулагддаг бөгөөд сонгуулийн төв байгууллага нь Үндэсний сонгуулийн комисс, хот-дүүрэг, дүүрэг-хот-сум,



хороо-баг-тосгон гэсэн 4 нэгжид байгуулагддаг. Монгол Улсын сонгуулийн байгууллагын тогтолцооноос ялгарах онцлог нь засаг захиргааны нэгжид үндэслэн байгуулагддаг сонгуулийн дунд, анхан шатны байгууллагууд нь байнгын ажиллагаатай байдаг. Мөн Үндэсний сонгуулийн хорооны дэргэд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа, хэлэлцүүлэг хариуцсан, Телевизээр нэвтрүүлэх сонгуулийн мэтгэлцээн хариуцсан, Үндэсний сонгуулийн санал асуулгын талаарх хэлэлцүүлэг хариуцсан 3 бие даасан зөвлөл ажилладаг.

Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь дэргэдээ Хэвлэл, мэдээллийн зөвлөл ажиллуулах эрх зүйн орчин хуульчлагдсан боловч 2012 оноос хойш энэхүү зөвлөлийг ажиллуулаагүй, учир

нь 2012 оноос хойш батлагдсан сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн сурталчилгаа, түүнд тавих хяналт, зохион байгуулалттай холбоотой харилцааг нарийвчлан тодорхойлсонтой холбоотой байдаг.

Мөн БНСУ-ын Үндэсний Сонгуулийн комиссын эрх зүйн байдлыг БНСУ-ын Үндсэн хуулиар тодорхойлсон бөгөөд уг хуулийн 114 дүгээр зүйлд "Сонгууль, ард нийтийн санал асуулгыг шударгаар удирдан зохион байгуулах, улс төрийн намуудтай холбоотой асуудлыг зохицуулах Сонгуулийн комисстой байх.", "Үндэсний Сонгуулийн комисс нь хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийг зохион байгуулж, санал асуулга, улс төрийн намын асуудалд хамаарах дүрэм, журмыг хууль тогтоомжид харшлахгүй хэмжээнд тогтоож болно.", "Түвшин бүрийн сонгууль зохион байгуулах хорооны зохион байгуулалт, чиг үүргийн хүрээ, шаардлагатай бусад асуудлыг

МУ-н Улс төрийн намын тухай хууль

2023 онд

шинэчилэн найруулсан.

Удирдах дээд байгууллага
Төлөөллийн төв
Гүйцэтгэх байгууллага
Хяналтын байгууллага
Бодлогын судалгааны
байгууллага

Идэвхгүйд тооцох

21.1.1. Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хоёр удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй;
21.1.2. энэ хуулийн 37.2-т заасан үүргээ зөрчин хоёр жил дараалан санхүүгийн тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй;
21.1.3. намын удирдах дээд байгууллагыг, эсхүл төлөөллийн төв байгууллагыг таван жилийн хугацаанд хуралдуулахгүй

БНСУ-н Улс төрийн намын тухай хууль

1962 онд

батлагдсан. 29 нэмэлт, өөрчлөлт

Дээд байгууллага
Төлөөллийн төв
Гүйцэтгэх байгууллага
Төсвийн хороо
Бодлогын судалгааны төв

Намын байгууллагын бүрэлдэхүүн тоог тогтоосон
Төв нам 100 хүртэл
Аймаг, нам нийт 100 хүртэл

хуулиар тогтооно.” гэж хуульчилжээ.

Харин Монгол Улс 1992 онд баталсан Үндсэн хуулиараа эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхаглан зарлаж, Монгол Улсын иргэд бүх нийтээрээ, сайн дурын үндсэн дээр, яс үндэс, угсаа гарал, шашин шүтлэг, нас хүйс, үзэл бодол үл харгалзан, чөлөөтэй, шууд, нууц санал хураалтаар төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох, түүнд сонгогдох эрхийг хуульчлан баталгаажуулж, сонгуулийг зохион байгуулж явуулах Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн үндэс суурийг тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлд Сонгуулийн төв байгууллага, түүний гаргах шийдвэрийн талаар тодорхойлон хуульчилсан нь үзэл баримтлалын хувьд,

НЭГДҮГЭЭРТ, Сонгуулийн төв байгууллага нь ард нийтийн санал асуулга, Монгол Улсын

Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал түүний гишүүнийг сонгох сонгуулиудыг зохион байгуулж явуулах үндсэн байгууллага нь Сонгуулийн төв байгууллага болохыг тодорхойлж;

ХОЁРДУГААРТ, Сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байна.

Дэлхийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагууд бүтэц, загварын хувьд олон янз байх ч сонгуулийн удирдлагын нийтлэг гурван төрөл буюу загвар байдаг. Үүнд бие даасан, засгийн газрын болон холимог гэсэн гурван загвар хамаарч байна. Харин БНСУ-н Үндэсний сонгуулийн комисс нь бие даасан загвар бүхий сонгуулийн удирдлагын байгууллагад хамаардаг.

Үндэсний сонгуулийн комисс нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч үндсэн 7 газар 18 хэлтэстэй бөгөөд

Ерөнхий нарийн бичгийн дарга болон түүний орлогчийн удирдлагад Ардчиллын төлөөх Солонгосын иргэний боловсролын институт ажилладаг бөгөөд уг институт нь бүх шатны сонгуулийн хороодын албан хаагчдад зориулсан сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Мөн сонгогчдод зориулсан сонгуулийн боловсролын үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулдаг. Энэхүү институт нь мөн сонгуулийн тогтолцооны талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэн зохион байгуулдаг байна.

Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгууль зохион байгуулах үндсэн үйл ажиллагаанаас гадна сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн агуулга, мөн чанарын талаарх мэдээлэл, сургалт буюу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд, тогтмол явуулж чадаж байгаа эсэх нь бие даасан, хараат бус байдлын шалгуур үзүүлэлт болж байдаг. Энэхүү шалгуур үзүүлэлт нь харьцангуй институтын чадавхтай холбоотой юм.

Харин Монгол Улсын хувьд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч сонгогчдод тэр дундаа залуу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн үйл явцын талаарх үнэн зөв мэдээлэл олгох үйл ажиллагааг тогтмол, өргөн хүрээнд явуулах шаардлагатай.

СОЛОНГОСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ИНСТИТУЦ



Хөтөлбөрийн дагуу БНСУ-ын Засгийн газрын харьяа агентлаг болох Солонгосын эмэгтэйчүүдийн хөгжлийн институцын үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл авах уулзалт зохион байгуулав.

Солонгосын эмэгтэйчүүдийн хөгжлийн институт нь 1983 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд анх байгуулагдахдаа шийдвэр гаргах түвшиндэхэмэгтэйчүүдийноролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн нийгмийн болон улс төрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд эмэгтэйчүүдийн улс төрийн эрх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх эрх зүйн орчин тодорхой түвшинд бүрдэж, эмэгтэйчүүдийн нийгмийн аливаа асуудалдхандах,оролцоохийгээдулс төрийн идэвх нэмэгдэж эхэлсэнтэй холбоотойгоор уг байгууллагын үйл ажиллагааны чиглэл цэвэр судалгаа, шинжилгээний чиглэлтэй болон хөгжиж байна. Энэхүү институт нь нийт 160 гаруй албан хаагчтай бөгөөд албан хаагчдын

60 гаруй хувь нь доктор зэрэгтэй байна. Хүний нөөцийн энэхүү чадавхдаа тулгуурласан төрийн бүх шатны байгууллага, тэр дундаа хөгжлийн бодлого тодорхойлогч институт, нийгэмд чиглэсэн бүх төрлийн судалгаа, шинжилгээний ажил хийдэг байна. Судалгааны ажлын эрэлт, хэрэгцээ шаардлагыг ихэвчлэн ээлжит сонгуулийн дараагаар тодорхойлдог бөгөөд саналаа өгсөн сонгогчдоос олон талт, өргөн хүрээнд судалгаа авч цаашид хийгдэх судалгаа шинжилгээний ажлын үндсэн



чиглэлүүдээ тодорхойлдог байна. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн үндсэн нэг чиглэл нь сонгуулийн процессын эрх зүйн чиглэлээрх судалгаа, шинжилгээний ажлыг дэмжиж, цаашид энэ чиглэлээр тинк танк чиглэлийн хөгжлийг дэмжих зорилготой тул уг зорилгын хүрээнд Солонгосын эмэгтэйчүүдийн хөгжлийн институттай судалгаа, шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийллээ. Мөн уг институт нь Монгол Улсын Жендерийн үндэсний хороотой хамтран ажиллах санамж бичигтэй бөгөөд санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах боломжтой болохыг тодорхойлсон үр дүнтэй уулзалт, сургалт болов.

Улс төрийн намын санхүүжилт, Улс төрийн намын тухай хууль болон сонгуулийн хуулиуд дахь жендерийн

эрх тэгш байдлыг хангах талаарх эрх зүйн орчин:

БНСУ-ын Улс төрийн намын тухай хууль нь 1962 онд батлагдсан бөгөөд нийт 29 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Улс төрийн намын тухай хуулиар улс төрийн намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, санхүүжилтийн хяналттай, ил тод байдлыг бэхжүүлэх, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр дэвшилттэй олон зохицуулалтыг хуульчилсан байна. Тухайлбал, Улс төрийн намын бүтцийн үндсэн 5 байгууллагыг тодорхойлон хуульчилсан бөгөөд үүнд Дээд байгууллага, Төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх байгууллага, Төсвийн хороо, Бодлогын судалгааны төвийн эрх зүйн байдлыг хуульчилжээ. Монгол Улсын хувьд 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар мөн намын

дотоод ардчиллыг бэхжүүлэх, бодлогын институт байх үндсэн чиглэлийн хүрээнд нам нь Удирдах дээд байгууллага, Төлөөллийн төв болон гүйцэтгэх байгууллага, Дотоод хяналтын байгууллага болон бодлогын судалгааны байгууллагатай байх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

БНСУ-ын улс төрийн намын тухай хуульд зааснаар төв нам нь 100 хүртэлх ажилтантай байх, намын дунд шатны байгууллага болох аймаг, хотын намын байгууллага нь нийт 100 хүртэлх албан хаагчтай байх зохицуулалтыг хуульчилсан нь намын санхүүгийн ил тод, хяналттай байдлыг тодорхойлоход ач холбогдолтой зохицуулалттай байна. Цаашид Монгол Улсын Улс төрийн намын тухай хуульд дээрх чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр нам, эвслээс нийт нэр дэвшигчдийн 30 хүртэлх хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байх, мөн сонгуулийн пропорционал тогтолцоогоор нэр дэвшигчдийг 1:1 хүйсийн дарааллыг баримтлан дараалалд оруулах талаарх зохицуулалтыг хуульчилсан. Харин БНСУ-н сонгуулийн хуульд зааснаар пропорционал тогтолцоогоор нэр дэвших нийт 47 нэр дэвшигчийн 50 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байх шаардлагатай бөгөөд сондгой тоо бүрд эмэгтэй нэр дэвшигч байх зохицуулалтыг хуульчилжээ. Гэвч энэхүү шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн намаас нэр дэвшигчдийг бүртгэхгүй байх талаар эрх зүйн орчин бүрдээгүй бөгөөд дээрх шаардлагыг намууд биелүүлэх талаарх зөвлөмж хүргүүлж ажилладаг байна. Монгол Улсын хувьд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар нэр дэвшигчдэд тавигдах дээрх хүйсийн шаардлагыг нам, эвсэл хангаагүй тохиолдолд нийт нэр дэвшигчдийг бүртгэхээс татгалзах зохицуулалтыг хуульчилсан нь шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах эрх зүйн үр дүнтэй зохицуулалт болжээ.

БНСУ-ын Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуульд зааснаар улс төрийн намын санхүүжилт болон олон нийтээс нам, эвсэлд өгсөн хандиваас бүрддэг бөгөөд онцлог нь иргэдээс нам, эвсэлд өгсөн хандив нь зөвхөн Үндэсний сонгуулийн комиссын улс төрийн намын санхүүжилтийн санд хуримтлагддаг бөгөөд нам олгох санхүүжилтийг тухайн нам, эвслийн сонгуулийн оролцсон үр дүн, санхүүгийн тайлан болон хуульд заасан бусад шаардлагыг хангаж байгаа байдалд үндэслэн хуваарилах зарчмыг баримталдаг. Мөн улс төрийн намд төрөөс олгож буй дэмжлэгийн зарцуулалтын үндсэн чиглэл, хувь хэмжээг тодорхойлон


хуульчилсан байдаг. Тухайлбал төрөөс олгож буй санхүүжилтийн тодорхой хувийг эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучуудын улс төрийн боловсролд зарцуулахыг хуульчилсан. Мөн сонгуульд нэр дэвшигчдийг тэгш өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх, сонгуульд зарцуулах зардлын тодорхой хувийг төрөөс дэмжих зохицуулалт нь улс төрийн намын санхүүжилтийн үндсэн нэг чиглэл болж байна.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо болон холбогдох оролцогч талуудад зориулсан Жендерийн мэдрэмжтэй хуулийн хэрэгжилтийг дэмжсэн мэдээлэл авах, туршлага судлах хөтөлбөрт тавигдсан үндсэн зорилгын хүрээнд шаардлагатай мэдээллийг оролцогчид бүрэн авч чадсан бөгөөд Улс төрийн намын

тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгагдсан жендерийн талаарх зохицуулалтын хэрэгжилтийг хангахад шаардлагатай зохион байгуулалт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой үр дүнтэй сургалт боллоо. Мөн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь улс төрийн намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, намын үйл ажиллагаа болон санхүүжилтийн ил тод байдлыг хангах чиглэлээр Ардчилал өндөр хөгжсөн улс орны энэ чиглэлээрх хууль тогтоомжид орсон онцлог бөгөөд гол зохицуулалтыг бүрэн тусгасан, зарим талаар илүү дэвшилттэй зохицуулалтуудыг тусгасан хууль батлагдсан гэх ерөнхий ойлголтыг авсан үр дүнтэй арга хэмжээ болж чадлаа.







04

СУДАЛГАА

- Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

25

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ТӨСӨӨЛӨЛ



С.ТҮМЭНДЭЛГЭР

Судалгааны багийн ахлагч, МУБИС-ийн багш, доктор, дэд профессор

"Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн багийн гүйцэтгэсэн судалгааг хэсэгчлэн толилуулж байна. Судалгааны тайланд тусгагдсан дүгнэлтүүд судалгааны багийн байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын КОЙКА Олон Улсын байгууллага болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

УДИРТГАЛ



1.1. Судалгаа явуулах хэрэгцээ, шаардлага

Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо, төлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг тодорхойлох давтамжит судалгааг 2010-2011 онуудад НҮБХХ, ЖҮХ-ны дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн. 2011 оноос хойш эмэгтэйчүүдийн оролцоонд хамаарах хууль (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль),

бодлого (Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Алсын хараа-2050, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөө (2013- 2016), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр (2017-2021), орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрүүд, салбарын жендэрийн бодлогууд) боловсруулж батлан, энэ чиглэлд ахиц дэвшил гарчээ. Гэвч парламентын болон гүйцэтгэх засаглалын удирдлагын түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жинд дорвитой өөрчлөлт гарахгүй байна. Тухайлбал, Монгол Улсын нийт сонгогчдын 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг, эмэгтэйчүүдийн сонгуулийн идэвх эрэгтэйчүүдээс илүү атлаа УИХ дахь төлөөлөл 17.3 хувь, дэлхийн дунджаас 8 орчим хувиар бага байна (ЖҮХ, 2020). УИХ-ын 2020 оны сонгуульд 151 эмэгтэй нэр дэвшсэн нь нэр дэвшигчдийн 24.9 хувийг эзэлж, 2016 онтой харьцуулахад нэг хувиар буурчээ.

Гэхдээ 2016 оны сонгуулийн үр дүнг давтсан эмэгтэй төлөөлөл УИХ-ын гишүүнээр сонгогдсон байдаг. Сонгуулийн үр дүнгээс харахад Монгол Улсад улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байсаар байна. Монгол Улсад өмнө хийгдсэн эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо, төлөөллийн талаарх ойлголт, хандлагыг тодруулах

судалгаа эмэгтэйчүүдийн оролцоог зөвтгөх хандлага, эмэгтэй улс төрчөөс хүлээх хүлээлт, эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийн төсөөллийг судлахад түлхүү чиглэж байсан. Сүүлийн үеийн судалгаагаар, тодруулбал Олон улсын эмэгтэйчүүдийн хөгжлийн агентлаг зэрэг байгууллагаас нийгмийн жендэрийн соёлын хэм хэмжээ, нийгмийн бүтэц, манлайлал дахь жендэрчлэгдсэн дүр үүрэг, хүлээлт, эмэгтэй улс төрчдөд учирч буй саад бэрхшээлийг тоон болон чанарын судалгааны аргуудаар нарийвчилсан мэдээлэлд үндэслэн судлах болжээ.

Иймд судалгааны баг эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны талаарх олон нийтийн төсөөллийг нэг талаас дээр дурдсан практик хэрэгцээ, нөгөө талаас цаашид хийх өөрчлөлтөд зайлшгүй шаардлагатай тоон болон чанарын өгөгдлийг шинэлэг арга зүйгээр цуглуулан, нарийвчилсан дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, эрх зүй, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ энэ чиглэлээр ажиллаж буй хувь хүн, байгууллагуудын өмнө дэвшигдэж байна хэмээн харж байна.



1.2. Судалгааны зорилго, зорилтууд

Судалгаа нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх олон нийтийн ойлголт төсөөллийг тодорхойлж, бодлогын болон нөлөөллийн үйл ажиллагаанд шаардагдах санал зөвлөмжийг боловсруулах зорилготой.

Хоёр. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд Баянхонгор, Завхан, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймгийн 24 сум, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан, Багануур, Налайх дүүргийн нийт 1006 хүн ам хамрагдсан.

Түлхүүр мэдээлэгчийн ярилцлагад УИХ-ын гишүүн, салбарын сайд 2.5 хувь, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны Засаг дарга, орлогч, газар, хэлтсийн дарга, төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга 44.4 хувь, ИТХ, ИНХ-ын дарга, тэргүүлэгч, төлөөлөгч 26.3 хувь, улс төрийн намын дарга, орлогч, ерөнхий нарийн бичгийн дарга 9.1 хувь, бизнес эрхлэгч 16.7 хувийг эзэлж байна.

Гурав. Судалгааны үр дүн



3.1 Жендэрийн хэвшмэл үзэл

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх олон нийтийн хандлагын судалгаанд жендэрийн хэвшмэл үзэлтэй нь холбон судалсан бүтээл нэлээд ажиглагдлаа. Үүнтэй холбоотойгоор судалгаанд оролцогчдын жендэрийн хэвшмэл үзлийг өрхийн хөдөлмөрийн хуваарь, шийдвэр гаргах болон хяналт тавих эрх мэдэл, олон нийтийн үйл ажиллагаанд дахь оролцоогоор хэмжихийг зорьсон болно. Гэр бүлийн хүрээнд хүүхдээ асрах, улс төрийн үйл ажиллагаанд хэн нь давамгай оролцох вэ гэсэн асуултаас бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь эн тэнцүү оролцоотой байх ёстойг илтгэсэн хариулт 50.3-76.6 хувьд нь илэрлээ. Ялангуяа өрхийн хэмжээний хөрөнгө нөөц захиран зарцуулах шийдвэр гаргах, гишүүдийн зан үйлийг хянах, асуудлыг шийдвэрлэх, нийгэм-улс төрийн үйл ажиллагаанд оролцоход эрэгтэй, эмэгтэйчүүд эн тэнцүү оролцоотой байхыг чухалчлах хандлага илт давамгайлж байна. Хэдийгээр өрхөд гэрийн ажил хийх, гэр бүлээ тэжээх үүргийг хуваарилахдаа “эн тэнцүү” гэсэн хариулт давамгай илэрсэн ч, гэрийн ажил хийхэд эмэгтэй хүн давуу үүрэгтэйг 43.1 хувь нь зөвшөөрсөн хариулт өгсөн атлаа гэр бүлээ тэжээх, өрхийн төсөв бүрдүүлэхэд эрэгтэй нь давуу үүрэгтэй гэж 44.8 хувь нь хариулжээ. Эндээс дүгнэхэд өрх дэх эрх мэдлийн зөрүү багатай байх ёстой гэсэн хандлага түлхүү илэрч байгаа ч, өрхийн хөдөлмөрийн хуваарьт хэвшмэл үзлээр хандах нь 40 гаруй хувьд нь илэрч байна.

...Улс төрийн үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэйчүүд ялгаагүй оролцох боломжтой гэж тал орчим (45.5 хувь) нь үзэж байгаа бөгөөд энэ нь “эмэгтэйчүүдээсээ илүү эрэгтэйчүүдийн ажил” гэх хандлагатай адил жинтэйгээр илэрч байна...



3.2. Улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжих байдал

Олон нийтээс улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжиж буй байдал, шийдвэр гаргах түвшинд ажиллахад эмэгтэй хүнд итгэл хүлээлгэх, дэмжих хандлага, түүний шалтгааныг тодруулсан. Судалгаанд оролцсон эрэгтэйчүүд эрэгтэй хүнээ шийдвэр гаргах түвшинд дэмжих хандлага 58.9 хувь, эмэгтэйчүүд эмэгтэй хүнийг дэмжих хандлага 28.5 хувьтай илэрснээс эрэгтэй хүн эрэгтэйгээ дэмжих хандлага эмэгтэйчүүдтэй харьцуулахад даруй 30 гаруй хувиарилууг харж болохоор байна. Харин эмэгтэйчүүдийн 48.3 хувь нь аль аль хүйсийн хүнийг дэмжиж байгаа

бөгөөд эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага эрэгтэйчүүд эмэгтэй хүнийг дэмжсэнээс 17 хувиар илүү байгаа тул эмэгтэйчүүдэд дэмжих хандлага илүүрхэж байна. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэхгүй байгааг “эмэгтэйчүүд нэгнийг дэмждэггүй” гэж чанарын судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд өгснийг энэ баримт үгүйсгэж байна. Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт судлагдсан эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дийлэнх олонх буюу 80 гаруй хувь нь итгэлтэй байна. Мэдлэг боловсролтой, шударга, үнэнч, ажил хэрэгч, хариуцлагатай, шийдэмгий, чадвартай зэрэг шинж чанар нь эмэгтэйчүүдэд итгэл үзүүлэх үндэслэл болсныг ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь илэрхийлсэн байна.

Матриц 3.1.2 Шийдвэр гаргах түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийг дэмжиж буй үндэслэл



Матриц 3.1.3 Эрэгтэй ба эмэгтэй хүнийг дараах байдлаар тодорхойлж байна:




3.3 Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх үзэл бодол

“УИХ-ын 76 гишүүний 17 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа”-г судалгаанд оролцогчдын 42 хувь нь хангалтгүй, 39.6 хувь нь боломжийн, 25.9 хувь нь хангалттай гэж үзжээ. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 48.8 хувь нь хангалтгүй гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 65.5 хувь нь боломжийн, хангалттай гэж үзсэн үр дүн хүйсээс хамаарч ($\chi^2 = 22.917$, $p < .001$) байгаа нь ажиглагдлаа.

УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 17 хувийг эзэлж байгааг “хангалтгүй” гэж хариулсан оролцогчдоос үүний шалтгааныг тодруулсан юм. Олон нийтийн 136.2 хувь (давхардсан тоогоор) эцгийн эрхт ёсны бүтэц, соёлтой холбоотой хүчин зүйлсийг гол шалтгаан гэж үзсэн. Тодруулбал, 39 хувь нь эмэгтэйчүүдийг ялгаварладаг, 30 хувь нь эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг хариуцлага, 28 хувь нь эрэгтэйчүүдэд төвлөрсөн эрх мэдлийн харилцаа, 18 хувь нь эрэгтэйчүүд давамгайлсан намын бүтэц, 12 хувь нь хууль, эрх зүйн орчин, 9 хувь нь санхүүгийн нөөцийн дутмаг байдалтай холбон тайлбарлажээ. Судлагдсан олон нийт УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй гэж үзсэн атлаа 118.3 хувь (давхардсан тоогоор) нь эцгийн эрхт ёсны бүтэц, соёлоо дэмжсэн, зөвтгөсөн хариулт өгсөн нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал тэдний хандлага болж чадахгүй байгааг харуулах юм. Тодруулбал, 27 хувь нь эмэгтэйчүүдийн хатуу, шийдэмгий биш, зоригтой бус байдал, 22 хувь нь эрэгтэйчүүдээс хамааралтай, 20 хувь нь эмэгтэй улс төрчид дорвитой зүйл хийж чаддаггүй, 19 хувь нь өндөр албан тушаал хашсан туршлага бага, 14 хувь нь эмэгтэйчүүд олон ачаалалтай тул улс төрийн ажлыг эрэгтэй хүн хийх нь зөв гэх эрэгтэйчүүдийг давууд үзсэн хандлагаар хариулжээ. Сонгогчийн хүчин зүйлстэй холбон үзэж 41.5 хувь нь тайлбарласан бөгөөд тодруулбал, 21 хувь нь сонгогчид эмэгтэй хүнийг сонгоход бэлэн бус, 20 хувь нь сонгогчдын боловсрол дутмаг гэж үзсэн байна.

Эндээс үзэхэд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай бус байгаагийн шалтгааныг оролцогчид нийгмийн бүтэц, соёлын дараах хүчин зүйлстэй холбон тайлбарлаж байна. Малчин болон ахмад эмэгтэйчүүдээс бусад бүх бүлгийн оролцогчид үүнд хамаарах шалтгааныг дор хаяж нэгийг илэрхийлж байв.

Зураг 3.3.2 УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн шалтгааны талаарх үзэл бодол (олон сонголтот хариултаар)



Үүнд:

- Эрэгтэй давамгайлсан улс төрийн бүтэц. Энэхүү санаа эрэгтэйчүүд нь шийдэж байна, эрэгтэйчүүд хор найруулаад шийддэг, эрэгтэйчүүдийн өрсөлдөөн явагддаг гэсэн тайлбараар илэрч байв.
- Хөрөнгө чинээ бага. Эмэгтэйчүүд хөрөнгөөр эрэгтэйчүүдээс бага байна, сонгууль хөрөнгөтэй хүмүүсийн өрсөлдөөн болсон, сонгуулийн зардлаа даах боломжоор хомс байна, сонгуулийн зардал өндөр хэмээн тайлбарлаж байв.
- Гэрийн хөдөлмөрийн ачаалал. Үр хүүхдээ өсгөх, гэрийн олон зүйлд санаа тавьдаг тул улс төрд зарцуулах цаг заваар хомс, боломжгүй байдаг гэх зэргээр илэрхийлж байв.
- Улс төр бол эрэгтэйчүүдийн ажил гэх соёл. Эрэгтэй хүн хүчирхэг гэж ойлгодог, эмэгтэй хүн улс төрч биш гэсэн соёл байгаагаас улбаалж байна хэмээн нэг хэсэг нь тайлбарласан.
- Бохир улс төр. Улс төрийн карьер нь илүү бохир, цүнх барих, гар хөл нь болох зэргээр ахиж дэвшдэг тул эмэгтэй хүнд зав байхгүй, татгалздаг гэсэн хариултууд үүнд хамаарах юм.

- Эмэгтэй улстөрчийн тухай мэдээлэл дутмаг байдал. Юу хийсэн, ямар асуудлыг шийдсэн гэдэг мэдээлэл сонсогддоггүй нь нөлөөлж байна гэж цөөн тооны оролцогч үзэж байлаа.


...Эцгийн эрхэт ёсны соёлын нөлөө эмэгтэй улс төрчдийн карьерт саад тотгор болдгийн жишээг ТМЯ-д оролцогч бодит жишээгээр илэрхийлснийг дурдвал “Эмэгтэй Засаг даргатай (сумын) болсноор хур бороо орохоо байж, зуншлага тааруу байх боллоо” гэх зэргээр эмэгтэй улстөрчийг хүйсийн шинжээр нь дорд үзэх хандлага гаргадаг гэсэн билээ. Дээрхээс ялгаатай байр суурийг орон нутгийн эмэгтэйчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас харж болох ба тодруулбал, орон нутагт сумын засаг даргаар ажилласан эмэгтэй улстөрчийг эрэгтэй улстөрчтэй харьцуулж, түүнийг удирдах ажил хийх илүү давуу талтайг практикаас мэдэрсэн олон нийтийн эмэгтэй улстөрчийн талаарх санаа бодол өөрчлөгдөж байгааг харууллаа.

...Бүлгийн ярилцлагад оролцогчдын өгсөн мэдээллээр, эмэгтэй улстөрчийн тухай мэдээлэл эрэгтэй улстөрчидтэй харьцуулахад хангалттай гардаггүй бөгөөд гол төлөв шүүмжилсэн, харлуулсан сөрөг мэдээлэл зонхилдог гэсэн хариулт ялангуяа эмэгтэй оролцогчдын дунд давамгайлж байв. Эмэгтэй оролцогчид хамгийн сүүлд авсан мэдээллээ хуваалцахад, эмэгтэй улс төрчийн талаарх эерэг гэхээсээ сөрөг голдуу мэдээлэл авсан байв. Харин авсан мэдээллэдээ хэрхэн хандаж байгааг нягтлахад цөөн эрэгтэй оролцогч сөрөг мэдээлэлтэй санал нэгдсэнээс бусад тохиолдолд “сөргөөр” илэрхийлж байгаад эргэлзэж шүүн тунгаан хэлэлцжээ. Дурдсан мэдээллээс нь харахад эрэгтэй улстөрчийг сөргөөр илэрхийлсэн мэдээлэл нь эмэгтэй улстөрчтэй харьцуулахад цөөн байна.

Гэхдээ эрэгтэй улстөрчдийн талаар ч сөрөг мэдээлэл давамгайлдаг гэж судалгаанд оролцогчид дүгнэж байсныг дурдах нь зүйтэй. Эмэгтэй улстөрчийн тухай мэдээлэл цөөн байгаагийн шалтгааныг эрэгтэй улс төрчдийн зүгээс тодорхой эмэгтэй улс төрчийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байсан мэдээлэлтэй нь холбон тайлбарласан бөгөөд хэвлэл дэх дүр төрх олон нийт, сонгогчдын дэмжлэгийг хүлээн авах эсэхэд ихээхэн үүрэгтэйг илэрхийлж байна. Тодруулбал, эмэгтэй улстөрчийн боловсруулсан, өргөн барьсан хууль, шийдвэрийг бус харин хэвлэл болон нийгмийн сүлжээгээр шүүмжлэл дагуулсан хуулийн төслийн нэрийг онцлон тэмдэглэж байлаа. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх сонгогчийн хандлага, үзэл бодол төлөвшихөд авч буй мэдээллийн төрөл ихээхэн нөлөөтэй. Иймээс судалгаанд оролцогчид эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар ямар төрлийн мэдээлэл авч буйг тодруулсан юм. Асуулга судалгаанд оролцогчдын дунд эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаарх сайн, муу холимог мэдээлэл авах

нь давамгайлж байгаа бол эрэгтэй улс төрчийн талаар сөрөг мэдээлэл авсан гэж хариулсан хувь эмэгтэй улс төрчөөс бараг 10 хувиар илүү байна (Зураг 3.3.3).

Зураг 3.3.3 Улс төрчдийн талаар авсан мэдээллийн төрөл, хувиар




Зураг 3.3.4 Улс төрчдийн талаар авсан мэдээллийн төрөл



Матриц 3.3.4 Эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл хүлээн авсан байдал, хариу үйлдэл, үнэлгээ

Эмэгтэй улс төрчийн тухай	Эрэгтэй улс төрчийн тухай
Мэдээлэл хангалттай гардаг эсэх: Үгүй	Мэдээлэл хангалттай гардаг эсэх: Тийм
ЭРЭГ МЭДЭЭЛЭЛ: Халамжийн хуулийн өөрчлөлт хийх тухай Замын хөрөнгө оруулалтыг шийдсэн Эко жорлонгийн тухай	ЭРЭГ МЭДЭЭЛЭЛ: Ганцаараа сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн
Мэдээллийг хүлээн авсан байдал: Эергээр хүлээн авсан. Халамжийн хуулийг өөрчлөхдөө сайтар судлах шаардлагатай	Мэдээллийг хүлээн авсан байдал: Эергээр хүлээн авсан.
Эерэг мэдээлэл давамгайлдаг эсэх: Үгүй	Эерэг мэдээлэл давамгайлдаг эсэх: Үгүй
СӨРӨГ МЭДЭЭЛЭЛ: Олон нөхөр сольсон, Хөшөө нураасан Хуулийн төсөл боловсруулахад оролцсон атлаа дараа нь эсэргүүцсэн Дээдний хэргийн тухай хууль гаргах Их хэмжээний хятадууд оруулж ирэх гэж байгаа тухай Унтдаг, боов иддэг Тамхины хууль баталчихаад өрөөндөө архи, тамхи хэрэглэсэн	СӨРӨГ МЭДЭЭЛЭЛ: Бэлгийн дарамт үзүүлдэг Цахим үндэстэн шоугаар Ковид тараасан Копи Анантай уулзлаа гэдэг мэдээлэл Боксын холбоог самарсан
Мэдээллийг хүлээн авсан байдал: Мэдээлэлтэй санал нэгдсэний зэрэгцээ эсэргүүцэж, шүүмжилсэн	Мэдээллийг хүлээн авсан байдал: Мэдээлэлтэй санал нэгдсэн. Мөн "Ховч хүүхэн шиг үсчиж ярьдаг" гэж сэтгэгдлээ хуваалцсан
Сөрөг мэдээлэл давамгайлдаг эсэх: Тийм	Сөрөг мэдээлэл давамгайлдаг эсэх: Тийм



3.5 Улс төрийн манлайлагчаас хүлээх хүлээлт: жендэрчлэгдсэн байдал

Тоон судалгаагаар, олон нийт манлайлагчаас ямар

тодорхой чанаруудын хүсэн хүлээж байгааг болон аль чанарыг эрэгтэйд, эмэгтэйд түлхүү хамаатуулж байгааг шинжилсэн. Манлайллыг есөн чанараар хэмжихэд олон нийт үүнээс 8-ыг хүйсээс хамаарахгүй адил гэсэн хариулт давамгайл элэрсэн ч дөрвөн чанарт нь буюу байгууллага, хамт олныг удирдах, бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах, шинийг санаачилж, өөрчлөлтийг авчрах, сэтгэн бодох чадварын хувьд эмэгтэйтэйгээсээ эрэгтэй нь илүү байдаг гэж үзлээ.

Олон нийтийн санаа бодлын хувьд бүлэг, байгууллага удирдах, чиглүүлэх, нөлөөлөхтэй холбоотой чанаруудыг эрэгтэйд, үлгэрлэл, шударга, хариуцлагатай, уян хатан гэсэн чанаруудыг эмэгтэйд хамааруулсан хандлага илэрчээ. "Эмэгтэй нь илүү" гэсэн хариултын дүн "эрэгтэй нь илүү" гэсэн хариултын нийт дүнгээс 5 хувиар их байна.

...Олон нийт улс төрийн манлайлагч хүнд байх ёстой гэж үзэж буй чанаруудыг олон сонголттой хариултын хувилбараар тодорхойлж нэгтгэн нэгтгэн дүгнэсэн юм. Олон нийтийн сонгосон хариултаар, улс төрийн манлайлагчаас шийдэмгий (83.4 хувь) чанарыг хүссэн нь хамгийн өндөр давтамжтай илэрсэн бол үүний дараагаар 66.8 хувь нь зоригтой байх, 59.3 хувь нь бусдыг ойлгодог байхыг чухалчилах хандлагатай байна. Эндээс дүгнэхэд, олон нийт ихэвчлэн эрэгтэй улстөрчдөд хамаатуулдаг шийдэмгий, зоригтой, тэмцэгч чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээдэг байгаа буюу улстөрчийг эрэгтэй чанараар хардаг ажээ.

Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж



Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх төсөөлөл

Дүгнэлт

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих эсэх талаар судалгаанд оролцогчид хариулахдаа улс төрд эрэгтэй, эмэгтэй адил тэгш оролцохыг дэмжих хандлагатайгаа илэрхийлжээ. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд улстөрчдийг хүйс харгалзахгүй дэмжиж байсан бол эрэгтэй оролцогчид эрэгтэйчүүдэд түлхүү итгэл үзүүлэх хандлагатай, хүйсээс хамааран сонголт хийх байдал давамгайлсан байна.

Эмэгтэйчүүд төрийн бодлогыг тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь итгэлтэй байна. Эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд сурталчилгаа хийх явцдаа

олон нийтийн дэмжлэгийг мэдэрч байсан төдийгүй 10-20 жилийн өмнөхтэй харьцуулахад эмэгтэйчүүдийг дэмжих байдал нэмэгдсэн хэмээн олонх нь хариулжээ. Эндээс дүгнэхэд олон нийт эмэгтэй улстөрчийг дэмжих хандлагатай болж байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь (66.6-69.6 хувь) эрэгтэй хүнд саналаа өгчээ. Энэхүү үр дүн нь эмэгтэй нэр дэвшигчийг дэмжиж байгаа эсэхийг тодорхой хэмжээгээр харуулах ч тухайн тойрогт эмэгтэй хүн дэвшсэн эсэхээс хамаарсан байна.

Жендэрийн хэвшмэл үзэл шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөтэй эсэхийг шинжлэхэд хэвшмэл үзэлтэй оролцогчдын тал нь эрэгтэй нэр дэвшигчийг, хэвшмэл ойлголтгүй хүмүүсийн 60 гаруй хувь аль алиныг нь болон эмэгтэй нэр дэвшигчийг дэмжихээ илэрхийлжээ. Эндээс дүгнэхэд жендэрийн хэвшмэл үзэлтэй эсэх нь эмэгтэй улстөрчийг дэмжих эсэхэд нөлөөлж байна. Жендэрийн хэвшмэл үзлийг тодруулахад оролцогчдын дийлэнх “хэт хэвшмэл үзэлтэн” биш бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг тогтоохыг дэмжих хандлагатай байна.

Гэхдээ өрхийн хөдөлмөрийн хуваарь, улс төрийн үйл ажиллагаан дахь оролцоонд хамаарах хэвшмэл үзэл хамгийн ихдээ 40-50 хувьд нь илэрч байна. Ялангуяа эрэгтэйчүүдэд хэвшмэл үзэл түлхүү илрэв. Мөн эрэгтэй хүнийг гэр бүлээ тэжээх үүрэгтэй, удирдах ажилд илүү тохиромжтой, 73 илүү чадвартай, илүү их үүрэгтэй гэсэн дүрээр, эмэгтэй хүнийг хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй, гэрийн бүх асуудлыг зохицуулдаг эцгийн эрхт ёсны дүрээр хүлээж байна. Чанарын судалгааны баримтаар удирдах ажлыг “эрэгтэй” дүрээр харж, хүлээж байгаа бөгөөд албан тушаал ахих тусам эмэгтэйчүүдэд итгэл хүлээлгэх хандлага буурч байв.

Асуулгын судалгааны дүнгээр эрэгтэй улстөрчийн талаарх сөрөг мэдээлэл авах нь эмэгтэй улстөрчөөс илүү байгаа хэдий ч чанарын судалгаанд оролцогчдын хувьд эмэгтэй улстөрчийн боловсруулсан, өргөн барьсан хууль, шийдвэрийг бус харин хэвлэл болон нийгмийн сүлжээгээр шүүмжлэл дагуулсан хуулийн төслийн нэрийг онцлон дурдаж байснаас нь эмэгтэй улс төрчдийн “хэл ам дагуулсан” мэдээлэл нь олон нийтийн ой санамжид үлдэх хандлага байна.



Эмэгтэй улстөрчийн
манлайллыг хөгжүүлэхтэй
холбоотой асуудлууд

Дүгнэлт

Хэн нь манлайлагч вэ гэдэгт “аль, аль нь” гэсэн төвийг сахьсан хандлага оролцогчдын дунд давамгайлж байна. Гэхдээ судалгаанд оролцогчдын 1/5 нь “эмэгтэйчүүд-

манлайлагч” гэдэгт итгэхгүй байна. Хүйсээр шинжлэхэд эрэгтэй нь эрэгтэйгээ, эмэгтэй нь эмэгтэйгээ “илүү” гэх хүйсийн хамаарал ажиглаглав.

Чанарын судалгааны дүнгээр манлайлагчийг “босс” байхтай адилтгах буюу авторитори маягийн манлайлагчийг “манлайлагч”-д тооцдог нийгмийн тодорхой хэсэг байгаа нь ажиглагдав. Манлайлагч улстөрчөөр эрэгтэй улстөрчийг түлхүү, харьцангуй цөөн эмэгтэй улстөрчийг нэрлэж байна. Үүнээс гадна улс төрийн болон удирдах албан тушаал хашиж байгаагүй цөөн улстөрчийг нэрлэхдээ гол төлөв “жагсагч, тэмцэгч” гэсэн нэрээр “танигдсан” улстөрчдийг нэрлэж байна.

Олон нийтийн олонх нь “шийдэмгий”, “зоригтой”, “тэмцэгч” зэрэг эр шинж байдлыг улстөрчдөөс хүлээж, нэг талаас зоригтой, үгээ дайчин, гал цогтой илэрхийлдэг байх, нөгөө талаас даруу, төлөв төвшин гэсэн эсрэгцсэн чанарыг эмэгтэй улстөрчөөс хүлээдэг нь давхар буюу илүү өндөр шаардлага тавьдагийг нотолж байна.

Зөвлөмж

Манлайлал, манлайлагчийн талаарх олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг нэгд, ардчиллыг гүнзгийрүүлэх, хоёрт, эмэгтэй улстөрчдийг ардчиллыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй талаас анхаарч, манлайллын орчин үеийн, ардчилсан хэв шинж рүү түлхүү чиглүүлэх шаардлагатай байна. Эмэгтэйчүүдийг улс төрд дэмжих нь зүйтэй гэсэн уриалгын шинжтэй үйл ажиллагаа гэхээсээ улс төрийг эмэгтэй хүний нэгэн ажил алба, эмэгтэй хүний нэг дүр-улстөрч гэсэн дүрийн хүлээлтийг олон нийтэд төлөвшүүлэх буюу улс төр дэх жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөхөд чиглэсэн цогц, тогтвортой, тууштай арга хэмжээг талуудын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

...Оролцогч талуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын төлөөх сайн дурын бүлэг, хувь хүн багтаж байгаа эсэхийг нягтлан, тэдгээрийг ашиглан олон нийттэй ажиллах үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, иргэд олон нийтэд хүргэх олон талт сувгуудыг үр дүнтэй, идэвхтэй бөгөөд тасралтгүй, тогтвортой ашиглах стратегийг хэрэгжүүлэх нь зүйтэй. ...Эмэгтэй улстөрчдийг бэлтгэх хөтөлбөрийн агуулгад манлайллын боловсролын агуулгыг цогцоор тусгахын хамт насанд хүрэгчдийн сургалтын арга зүйд тулгуурлах, хийнгээ суралцах, амьдрал, үйл ажиллагаанд нь туршин, ашиглаж, сайжруулангаа суралцах боломжийг олгосон байхад анхаарах нь зүйтэй юм. Олон нийттэй харилцах ажилд үйлийн судалгаа (action research)-г ашиглаж, нэг ажлаас нөгөө ажилд шилжихэд чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарах шаардлагатай.

Хүснэгт 1. Сонгогчийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 2. Сонгогчийн үндсэн үзүүлэлтүүд



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО СУДАЛГААНЫ САН



ҮНДСЭН НҮҮР



СОНГУУЛЬ



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД
БАЙДАЛ



МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА,
СУРГАЛТЫН ТӨВ



МЭДЭЭЛЛИЙН САН

Хаяг

Өргөдөл, гомдол, санал хүсэлт

Бидэнтэй холбоо барих

Сошиал хуудас



05

ЦАХИМ НОМЫН САН

- Сонгуулийн ерөнхий хороо цахим номын сантай болно


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

33

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ЦАХИМ НОМЫН САНТАЙ БОЛНО.

Б.Батхишиг

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн референт




чиглэсэн судалгаа, шинжилгээнд суурилсан санал, шүүмжлэл байдаг тул сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийг ил тод, шударгаар явуулах эрх зүйн орчныг хөгжүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, судалгаа, шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Сонгууль бүрээр маш олон төрлийн дата мэдээлэл үүсдэг боловч энэхүү цугларсан дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгаа, шинжилгээний зорилгоор эргэлтэд оруулах боломжгүй буюу цаасан хэлбэрээр байгууллагын архивт хадгалагдаж байдаг. Иймд уг мэдээллийг судалгааны эргэлтэд оруулах, судалгаа шинжилгээний ач холбогдлыг нэмэгдүүлэх, нийтэд нээлттэйгээр ашиглуулах хэрэгцээ, шаардлага үүсч байгаа тул эдгээр дата мэдээлэл болон сонгуулийн холбогдолтой ном, гарын авлага, байгууллагаас эрхлэн гаргадаг сэтгүүл, хууль журмын эмхэтгэл зэргийг цахим хэлбэрт шилжүүлэн мэдээллийн сан үүсгэж иргэд сонгогч, судлаач, олон нийтэд үнэ төлбөргүй ашиглуулах, нийтийн хүртээл болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улс сонгуулийг ямар тогтолцоогоор зохион байгуулж явуулах нь оновчтой байх тухай дүгнэлт, санал, шүүмжлэл дэвшүүлсэн судалгааны ажил, эрдмийн зэрэг горилох бүтээл, нийтлэл олон байдаг ч аль тогтолцоог ашиглахаас үл

хамааран сонгуулийг ил тод, шударгаар зохион байгуулж явуулах эрх зүйн орчны талаарх дотоодын судлаачдын судалгааны бүтээл ховор байна.

Аливаа эрх зүйн хөгжлийн үндэс бол түүнийг сайжруулахад



06

СОНГУУЛИЙН ТҮҮХ

- Хороо далбаатай болов

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН

35

ХОРОО ДАЛБААТАЙ БОЛОВ



Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномцэрэн, нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан нарын гарын үсэг бүхий 2016 оны нэгдүгээр сарын 6-ны өдрийн 01 тоот тогтоолоор Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны далбааны эх загварыг баталсан байна. Уг далбаа нь цэнхэр өнгөтэй байх бөгөөд далбааны дэвсгэрийн төв хэсэгт Сонгуулийн Ерөнхий Хорооны бэлгэ тэмдгийг байрлуулж, өргөн нь 90 см, урт нь 190 см, бэлгэ тэмдгийн өндөр нь 55 см, өргөн 85 см байхаар тогтоосон байна.



Сонгуулийн Ерөнхий Хорооны бэлгэ тэмдгийг засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх санааны илэрхийлэл, төрийн үйл хэргийг тасралтгүй явуулахын бэлгэдэл болгохдоо

Дугуй зууван хэлбэрээр:

сонгуулийг хууль ёсны дагуу тойргоор зохион байгуулж явуулдгийг илэрхийлж;

Төрийн далбаагаар:

түүний бүх нийтийн, эрх тэгш, чөлөөтэй, шууд явагдах зарчмыг төлөөлүүлж;

Монгол орны нутгийн дүрсээр:

сонгуулийг нутаг дэвсгэрээр зохион явуулдаг санааг илтгэж;



Төвд нь нарыг байрлуулж, түүний алтан шаргал туяагаар:

Монгол түмэн төрөө ардчилсан сонгуулиар өнө мөнхөд байгуулах утгыг дүрсэлж;

Бадам цэцгээр:

сонгогч түмэн сүүн цагаан сэтгэлээр сонгуульд шударгаар оролцдогийг бэлгэдэж үйлджээ.

Эрдмийн алтан соёмбоор:

төрөө төвхнүүлэхэд сонгуулийн байгууллагын хараат бус, бие даасан үйл ажиллагааг харуулж;





07

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Б.Нямцэрэн: Залуус сонгуульд утга учиртай оролцож, саналаа өгөх нь ирээдүйдээ оруулж буй чухал хөрөнгө оруулалт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

39



Б.НЯМЦЭРЭН:

**ЗАЛУУС СОНГУУЛЬД УТГА
УЧИРТАЙ ОРОЛЦОЖ,
САНАЛАА ӨГӨХ НЬ
ИРЭЭДҮЙДЭЭ ОРУУЛЖ БУЙ
ЧУХАЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

*“Лийд төгсөгчдийн холбоо” ТББ-ын Удирдах
зөвлөлийн дарга Б.Нямцэрэнтэй ярилцлаа.*

Тус төрийн бус байгууллагатай Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж эхэлсэн билээ.

**“Лийд төгсөгчдийн холбоо”
ямар үйл ажиллагаа явуулдаг
байгууллага билээ? Манай
уншигчдад мэдээлэл өгнө үү?**

“Лийд төгсөгчдийн холбоо”-г 2018 онд ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, тэгш, хүртээмжтэй, хүний эрхийг дээдэлсэн нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй залуус сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан түүхтэй. Бид өнгөрсөн зун зургаадугаар сард 5 жилийн ойн баяраа амжилт, бүтээлээ дүгнэж, цаашдын зорилгоо хэлэлцэн тэмдэглэсэн. Байгуулагдсан цагаасаа хойш манай холбоо нийгмийн өөрчлөлтийн 12 төсөл хэрэгжүүлснээс хамгийн амжилттай, үр нөлөөтэй нь Сонгуулийн ерөнхий хороотой хамтран хэрэгжүүлсэн төслүүд байжээ. Үүнд, Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль, мөн 2 удаагийн нөхөн сонгуулийн үеэр сонгуулийн ирцийн мэдээг хүлээн авах, нэгтгэх, дамжуулах систем хөгжүүлж, сонгуулийн өдөр сонгогчид ирцийн мэдээллийг хэд хэдэн ангиллын хүрээнд цаг алдахгүй авах боломжийг бүрдүүлсэн явдал юм. Энэхүү систем нь газар зүйн мэдээллийн системд суурилсан тул иргэдэд маш ойлгомжтой. Аль тойрог, орон нутагт хэдээс хэдэн насны сонгогч сонгуульд идэвхтэй оролцож байгааг харах, цаашдын сонгуулийн дараа ирцийн мэдээлэлд анализ хийхэд маш тохиромжтой буюу насны ангиллыг маш дэлгэрэнгүй болгож Монгол Улсын суурь статистикийн мэдээллийн форматтай адил болгосноороо давуу талтай юм.

Сонгуулийн Ерөнхий хороотой хамтран хэрэгжүүлсэн төслүүдээ дурдлаа. Цаашид СЕХ-той хамтран ажиллахаар санамж бичиг байгуулсан, энэ талаар мэдээлэл өгөөч?

Бид 2020 оноос СЕХ -той хамтран ажиллаж байна. Сонгуулийн дата хакатон тэмцээнийг залуучуудын дунд зохион байгуулахдаа анх СЕХ-ноос төлөөлөл урьж, шүүгчээр ажиллуулж байсан. Үүний дараа сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдлын судалгаа, сонгуулийн ирцийн систем зэргээр сонгуулийн холбогдолтой бүхий л төсөл хөтөлбөрүүд дээр маань СЕХ тодорхой хэмжээнд дэмжиж ажиллаж байна. Бид эдгээр амжилттай хэрэгжүүлсэн төслүүд, хамтын ажиллагааны туршлагаа бэхжүүлэх зорилгоор 2022 оны 10-р сард СЕХ-ны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвтэй хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Ирэх 2024 оны ээлжит сонгуульд сонгуулийн ирцийн мэдээллийг мэдээлэх, дамжуулах өмнөх туршлагыг сайжруулахаар дахин ажиллах хүлээлттэй байна. Түүнчлэн сонгуулийн ил тод байдал, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх асуудал нь манай холбооны ирэх хэдэн жилд анхаарч ажиллах тэргүүлэх чиглэл учраас санамж бичиг байгуулснаар хэрэгжүүлэх төслүүд маань илүү өргөн хүрээг хамарч, илүү үр нөлөөтэй байна гэдэгт илтгэлтэй байгаа.

Холбоо ер нь яагаад сонгуулийн ил тод байдал, сонгогчдын боловсрол чиглэлд үйл ажиллагаа явуулах болсон юм бэ?

Ардчилсан нийгмийн гол тулгуур бол чөлөөт, шударга сонгууль. Сонгууль чөлөөтэй, шударга байхын тулд түүнд оролцож байгаа иргэд нь мэдээлэлтэй, сонгуулийн процесс нь нээлттэй, хяналттай байх ёстой. Нийгмийн цөм хэсгийг бүрдүүлж

байгаа залуучууд сонгуулийн үйл явцад идэвхтэй, хариуцлагатай оролцдог болж байж нийгэм илүү гэгээлэг, шударга болно гэж бид итгэдэг. Тийм учраас манай Холбооны залуус сонгуулийн тогтолцоо, бодлогын асуудалд дуу хоолойгоо хүргэхийн зэрэгцээ сонгуулийн ач холбогдлыг таниулах, шийдэл санал болгох төслүүдийг санаачлан хэрэгжүүлсээр байна.

Цаашид ямар үйл ажиллагаа төлөвлөж байгаа вэ? 2024 оны сонгуулийн жилд танай Холбооноос залуусын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд юу хийхээр төлөвлөж байна вэ?

Их хурлын сонгуулийг угтаад холбоо хэд хэдэн сонирхолтой төсөл төлөвлөж байна. Бидний дараагийн төслийн фокус бүлэг бол сонгуулийн үйл явцад анх удаа оролцож байгаа шинэхэн сонгогчид байх болно. Монгол улс маань ардчилсан тогтолцоог сонгоод 33 жил өнгөрч байгаа ч залуучуудын дунд ардчиллын үнэт зүйлсийг ойлгох, түүнийг хамгаалах, бэхжүүлэх хандлага сул байгаа нь Улсын Их Хурлын болон бусад сонгууль дахь залуусын оролцоо, ирцийн мэдээнээс харагддаг.

Ерөнхий боловсролын сургуулиудад иргэний боловсролын хичээлд ардчилал, сонгуулийн талаар агуулга байдаг боловч хэт ерөнхий, мөн тухайн агуулгыг хүргэх арга хэлбэр нь өсвөр насныхны онцлогт нийцсэн эсэх нь эргэлзээтэй байдаг. Иймд бид өөрсдийн төслөөр дамжуулан ардчиллын үнэт зүйл, сонгуулийн талаар нэмэлт агуулгыг өсвөр үеийнхэнд, тэр дундаа анх удаа сонгуульд оролцох бүлэгт хүргэхээр шийдсэн. Шинэ төсөл маань есдүгээр сараас хэрэгжээд эхэлсэн. Хагас жилийн хугацаанд шинэ сонгогчдод чиглэсэн энгийн, сонирхолтой, танин мэдэхүйн контентууд, үе тэнгийн сургалт,

уралдаан зэргийг төлөвлөөд байна.

Төслийнхөө талаар жаахан дэлгэрүүлээч? Бусад төслөөс юугаараа онцлог байх вэ?

Увс, Ховд, Дархан-Уул, Дорнод, Дорноговь гээд таван аймгийн үе тэнгийн сонгогчдыг хамруулж, хамтдаа суралцаж, нөхөрлөх боломжийг олгохоороо төсөл маань онцлог. Хөгжилтэй, чөлөөт арга хэлбэрээр ардчилсан тогтолцооны онцлог, сонгуулийн ач холбогдлыг ойлгуулахад чиглэнэ. Бид өмнө нь 2020 оны сонгуулийг угтаад залуусын дунд анх удаа сонгуулийн дата хакатон зохион байгуулж байлаа. Маш амжилттай болж, уралдаанаас гарсан шилдэг санааг 2020 оны Их хурлын сонгуулийн үеэр цахим компани ажил болгон хэрэгжүүлсэн. Энэ удаад мөн адил төсөл маань залуусын шинэлэг санаа, бүтээлч байдлыг илрүүлж, тэдэнд санаагаа хэрэгжүүлэх, бодитоор нөлөөллийн ажил хийж үзэх боломжийг олгох юм.

Сайн дурын төсөл хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээл мэдээж байдаг байх. Танай холбоо аливаа улс төрийн нам, бүлгээс ангид, бие даан үйл ажиллагаа явуулдаг гэж ойлгосон. Санаачилсан төслийнхөө зардлыг хэрхэн шийддэг вэ?

Бид бусад иргэний нийгмийн байгууллагуудын адилаар шинэ санаагаа төсөл болгож бичээд олон улсын болон дотоодын санхүүжүүлэгч байгууллагуудад ханддаг. Энэ удаагийн шинэ залуу сонгогчдод чиглэсэн төсөлд маань Канадын сан дэмжлэг үзүүлж, зардлын санхүүжилт олгож байгаа.

Баярлалаа танд.





08

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- Б.Ундрал: Сургалтад хамрагдсан хүүхдүүд сонгуулийн үнэ цэнийг мэддэг болсон
- У.Ганбаатар: Сургалтад оролцох хүүхдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

43

Б.УНДРАЛ:

СУРГАЛТАД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮД СОНГУУЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ МЭДДЭГ БОЛСОН

Хариуцлагатай сонгогч
хөтөлбөрийн Баянгол
дүүрэг дэх сургагч багш
Б.Ундрал, Дорноговь
аймаг дахь сургагч багш
Э.Ганбаатар нартай
ярилцлаа



**Сургалт амжилттай болж
өндөрлөв үү? Сэтгэгдлээсээ
хуваалцаач.**

Би багадаа багш болохыг нууцхан мөрөөддөг байсан. Мөрөөдөл маань сонгуулийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх их үйлсэд гар бие оролцох “Хариуцлагатай сонгогч” бэлтгэх сургагч багш болон биеллээ олж, сургалтаа хоёр дахь удаагаа амжилттай явуулсандаа сэтгэгдэл маш өндөр байна. Энэ удаагийн сургалтыг өмнө нь цөөнгүй удаа сургалт явуулж байсан сургагч багш нартай хамтран зохион байгуулсан бөгөөд миний хувьд туршлага хуримтлуулсан үр өгөөжтэй сайхан сургалт болж өндөрлөлөө. Бидний сургалт, танилцуулга мэдээллийг хүүхдүүд маш идэвхтэй хүлээн авч байсан нь өмнөх сургалтад хэчнээн хамрагдахыг хүссэн ч нас нь хүрээгүй гээд хамрагдаагүй, уг

сургалтад оролцохыг тэсэн ядан хүлээсэн олон сурагч байсныг харахад урамтай сайхан байлаа.

Сургагч багш нар бид өмнө явуулсан сургалтын арга барил, туршлага дээрээ тулгуурлахаас гадна шинээр батлагдсан сонгуулийн хууль тогтоомжуудад орсон онцлог зохицуулалтууд, УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд дагаж мөрдөх дүрэм журмын шинэчлэл, мөн үндсэн хичээлүүдээр өгөх мэдээллийг хялбаршуулсан байдлаар сургалтыг явуулсан бөгөөд миний хувьд энэ удаагийн сургалтаас олон шинэ зүйлсийг сурагчид болон хамтран ажилласан сургагч багш нараасаа олж харж, сурч мэдсэн.

Энэ дашрамд сургагч багш биднийг үргэлж бүх талаар дэмжин шинэ мэдээ мэдээллээр хангаж, арга зүйн заавар, зөвлөгөө өгдөг Сонгуулийн Ерөнхий хорооны хамт

олон болон сургалт явуулах таатай орчныг бүрдүүлсэн “Монгени цогцолбор” сургуулийн удирдлага, нийт багш ажилчдад гүн талархснаа илэрхийлье.

**Хүүхдүүдийн хандлага ямар
байна? Сургалт эхлэх, дуусах
үеийг харьцуулахад хүүхдүүд
хэрхэн өөрчлөгдөж байна вэ?**

Сургалт эхлэх үеийн сурагчдаас ажиглагдсан нийтлэг нэгэн жишээг дурдахад, “сургуулиа төгсөөд гадаад хэлний шалгалт өгч гадаад явж сурах учир сонгууль нэг их чухал биш, энэ сургалт элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд л тус нэмэр болно, ямар ч хүн улс төрд гарсан бүгд адилхан” гэж аав маань хэлсэн гэх мэт сурагчдын хоорондын яриа, хандлагууд ажиглагдсан. Мөн сургалтыг эхлэх үед зарим сурагч цахим холбоосоор авсан улстөрчдийн шүүлтүүргүй

мэдээллийг ярьж, сонгуулийг юу гэж боддог вэ гэсэн асуултад ихэнх сурагч ямар нэгэн нам, эвсэл гэсэн ойлголтоор хариулж байсан. Үүнээс харахад залуу үе маань гадаад улсыг зорих чин хүсэл эрмэлзэлтэй болсон төдийгүй улс төр болон сонгуулийг нэг их сонирхдоггүй, цахим сүлжээний мэдээллээс хараат, эцэг, эхийн нөлөөнд хэт автдаг зэргээс харахад залуу сонгогчдын сонгуулийн боловсрол тааруу байгаа нь анзаарагдаж байлаа.

Харин сургалт дуусах үед манай сургалтад оролцогч хүүхдүүд хамтрагч багшаас маань нэмэлт давтлага авах, цаашид сонгуульд оролцох ангийн болон үеийн сонгогч найз нөхөд, хамаатны ах, эгчийгээ хүртэл сургалтад хамруулах чин хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн төдийгүй ялангуяа уг сургалтын агуулгыг ЕБС-ийн хөтөлбөрт нэмж, бүх нийтээр хамруулах саналтай байсан.

Сургалтын эхний өдрийн хичээлүүдээс хүүхдүүдэд юу ойлгож авснаа чөлөөтэй илэрхийлэх нэмэлт даалгавар өгөхөд оролцогч хүүхдүүд маань сургалтаас олж мэдсэн зүйлээ бүтээлч сэтгэлгээгээр гар зургаар гайхалтай илэрхийлсэн байсан. Манай ангийн нэгэн оролцогч сурагч маань хичээлийн төгсгөлд та ч бас залуу үеийн төлөөлөл шүү, энэ сургалтаа илүү олон сурагчид хүргээрэй гэж намайг зурсан зургаа өгсөн. Сургалт эхлэх үе болон дуусах үетэй хүүхдүүдийг харьцуулбал одоо тэд сонгуулийн үнэ цэнийг мэддэг, өөрсдөө идэвхтэйгээр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг харьцуулан уншиж судалдаг, сонгох, сонгогдох эрхээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэх чадвартай хариуцлагатай сонголт хийх сонгогчид болсон. Сургалтын төгсгөлд өмнө олон сургалт явуулж байсан туршлагатай сурагч багшийн сэтгэгдлийг сонсоход төвийн болон захын сургуулийн сурагчдын хандлага болоод идэвх, оролцоо нь өөр, өөр байгааг ажиглан хэлсэн нь дараагийн удаагийн





сургалтыг дүүргийн төв болон захын сургуулийн сурагчдын төлөөллийг оролцуулан явуулах сэдлийг надад төрүүлсэн.

Сургалтын явцад ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байна уу?

Сургалт явагдсан “Монгени цогцолбор” сургуулийн ханан дээр хүн бэрхшээлийг давахын тулд их ядардаг, түүнийг давангуут амжилт болдог гэсэн үгийг байрлуулсан байсан. Хоёр удаагийн сургалтыг явуулсныхаа дараа би энэ үгийн утгыг илүү их ойлгосон. Мөн сургалтын явцад багш гэх мэргэжлийн ажлын онцлог хийгээд тэдэнд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илүү их мэдэрсэн гэж

хэлж болно. Оролцогчид сэдэвтэй холбоотой багийн ажлыг цагаа барилгүй төлөвлөсөн цагаас удаан хийх, мөн цаашид гүнзгийрүүлэн судлах хүсэлтэй олон талын янз бүрийн асуулт асуух зэрэг хичээлийн цагт баригдах хүндрэлтэй ихээхэн тулгарч байсан. Түүнчлэн ахлах ангийн сурагч байна гэдэг амьдралынхаа гарааг эхлүүлэх маш хариуцлагатай үе. Яг энэ үедээ тэд ЭЕШ-д бэлдэх, даалгавраа хийх, хичээлээс гадуур сургалт, дамжаанд хамрагдах, гэр орондоо туслах гээд маш их ачаалалтай байдаг. Тиймээс сурагчдыг залхаалгүй олон талын сургалтын арга, барил ашиглаж хичээлийг орох, тухайн сэдэвтэй холбоотой мэдээ, мэдээлэл судалгаа зэргийг маш сайн уншиж судлах, цагаа зөв хуваарилан хичээлээ орно



гэдэг тухайн сургагч багшаас нөр их хөдөлмөр авьяас, чадвар шаарддаг юм билээ.

Сургалт орж байх үед манай ангийн оролцогч хэдэн хөвгүүд огт анхаарал хандуулахгүй, нэг хүүгийн яриаг их сонсоод л нөгөө хүү маань бусдадаа төвөг удаад, жаахан үймүүлэх аядаад байсан юм. Би тэгэхээр нь тэр хүүг миний орох хичээл дээр чи багш болно шүү бэлдээрэй гэж хэлээд суулгасан. Тэр хүүд тэгж хэлэхэд ангийн бусад үймүүлж байсан сурагчид суудалдаа суучихсан. Дараа нь нөгөө хүүг багш болгоход миний орох модуль хичээлийг цайны цагийн завсарлагаагаар уншиж, судалсан төдийгүй ангийн сурагчид ч түүнээс олон асуулт асууж байсан. Үүнээс би хүүхдүүд ойлгоогүй үлдсэн зүйлээ багшаас асуулгүй өнгөрөх тохиолдол олон гардаг юм байна, харин хүүхэд хүүхдээсээ бол асуугаад л ойлгоод авчихдаг юм байна гэж дүгнэсэн. Тиймээс эвийг нь олж, сурагчийг сурагчаар нь хөгжүүлэх нь үр дүнтэй юм шиг санагдлаа. Мөн багш хүн сурагчаа юун түрүүнд загнахаасаа өмнө жишээ нь хошигносон байдлаар шүүмжилбэл хүлээж авах нь илүү хурдан байсан.

Би өөрийгөө энэ удаагийн сургалтаар хүндрэл бэрхшээлтэй тулгарсан гэхээс илүүтэй өөртөө дүгнэлт хийж, туршлага хуримтлуулсан гэж бодож байна. Цаашид хариуцлагатай сонгогч залуу үеийг бий болгохын төлөө заах арга барилаа улам илүү чадавхжуулж, илүү олон залууст хүрч, дараагийн сургалтуудаа илүү сонирхолтой шинэлэг байдлаар зааж ажиллахыг зорьж, хичээх болно.






У.ГАНБААТАР: СУРГАЛТАД ОРОЛЦОХ ХҮҮХДИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

СУРГАЛТЫН ТАЛААР СЭТГЭГДЛЭЭСЭЭ ХУВААЛЦААЧ.

Энэ өдрийн мэнд хүргэе. Сонгуулийн ерөнхий хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд хэрэгжүүлж буй "Хариуцлагатай сонгогч" хөтөлбөрийн сургагч багш болж Дорноговийнхоо залуучуудад сургалт, мэдээлэл өгсөндөө баяртай байна. Энэхүү сургалтыг зохион байгуулснаар оролцогчид сонгуулийн талаар ойлголцогчид болох, залуу үеийн төлөөлөл нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, сонгуульд идэвхтэй оролцох нь цаашид ямар үр дүн гарах талаар мэдлэг олгох, багаар ажиллах, өөрсдийгөө илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг үр дүнтэй сургалт болсон.

ХҮҮХДҮҮДИЙН ХАНДЛАГА ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА?

Сургалтын зорилго, зорилтыг танилцуулан оролцогчид өөрсдийн



нэр, дууддаг нэр болон хэлэх дуртай үгийг бичиж бусдадаа танилцуулснаар маш сонирхолтой эхлүүлж хүүхдүүдийг багаар ажиллуулах, сэдэлжүүлэх дасгал ажил хийлгэх, лекц болон асуулт, хариултын аргыг ашигласан ба хоолны дараа дасгал хөдөлгөөн хийлгэх, тоглоом тоглуулах зэрэг хөгжилтэй байдлаар зохион байгуулсан. Мөн багаар дасгал ажиллуулах нь сургалтад оролцогчдыг багаар ажиллах чадвар, сэтгэн бодох, илтгэх үр чадварыг нэмэгдүүлсэн нь


сургалт эхлэх болон дуусах хүртэл хүүхдүүдэд сонирхолтой байсан.

СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЯМАР ШИНЭ САНААЧИЛГА ХЭРЭГТЭЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Цаашдаа хүүхэд залуучуудад уг сургалтыг үе шаттай тогтмол зохион байгуулах, оролцох хүүхдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж санагдсан. Энэхүү сургалтыг зохион байгуулж хамтран ажилласан бүх хүмүүстээ баярлалаа, Та бүхэндээ ажлын амжилт хүсье.







09

СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

- Д.Элбэрэл: Сонгуулийн ирц хамгийн их буюу 75.22 хувь байв

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

49

Д.ЭЛБЭРЭЛ:

СОНГУУЛИЙН ИРЦ ХАМГИЙН ИХ БУЮУ 75.22 ХУВЬ БАЙВ



Д.ЭЛБЭРЭЛ

Сонгогчдын боловсрол төвийн төслийн менежер

Тайланд улсын ерөнхий сонгуулийг ажигласан тэмдэглэл

2023 оны 5-р сарын 14-ны өдөр Тайланд улсын бүх нийтийн сонгууль болж, нийт хүн амын 75.22% буюу түүхэнд дэх хамгийн их сонгогч саналаа өгсөн сонгууль болж өндөрлөлөө. Өнгөрсөн 2019 оны сонгуультай харьцуулахад олон нийт, иргэд сонгогчдын сонгуулийн оролцоо, сонгуулийн дүнд итгэж буй байдлыг харахад энэ удаагийн сонгууль өндөр хариуцлагатай, ил тод, нээлттэй, бүх нийтийг хамарсан байж чадсан гэж харагдав. Гэсэн хэдий ч сонгуулийн зарим хэсэгт чанарын хувьд, шударга байх зарчмын хувьд санаа зовоосон асуудал байсаар байв.

Энэхүү сонгууль нь өмнөх сонгуулиудыг бодоход хамаагүй нээлттэй, ил тод орчинд явагдсан хэдий ч урьдын адил туйлширсан цэргийн дарамт, нөлөөнд өртсөн хэвээр ажиглагдав. Бүх талын оролцогч талууд үүнээс болгоомжилж байгаа нь илт байлаа. Сонгуулийн бүх талын оролцогчид сонгууль чөлөөт, шударга орчинд болохгүй байх хэмээн таамаглаж байсан ба сонгуулийн үр дүн нь цаашид Тайланд улс Ардчиллаа бэхжүүлж чадах үгүйг нотлон харуулна хэмээн үзэж байна.

Азийн сонгуулийн байгууллагуудын сүлжээ /ANFREL/ нь энэхүү сонгуулийн бүх үйл явцын ажиглахаар 19 орны 41 ажиглагчийг 7 хоногоос 2 сарын хугацаатай Олон улсын ажиглалтийн баг томилон сонгуулийн ажиглалт хийлээ. Монгол улсаас "Сонгогчдын Боловсрол" төвийн төлөөлөл 1 сарын хугацаатай урт хугацааны ажиглалт хийсэн ба сонгуулийн ажиглалтын тэмдэглэлээс хүргэж байна.

ANFREL нь Азийн хамгийн том сонгуулийн ажиглалтын баг бөгөөд ажлын алба нь Тайланд улсын Бангкок хотноо оршдог. Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь сонгуулийн ажиглалт, сонгуулийн чиглэлээр идэвхтэй ажиллаж буй ИНБ-ын чадавхыг нэмэгдүүлэх, ардчиллыг бэхжүүлэх болон ардчиллыг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад нөлөөлөх ажлыг тогтмол явуулж байна.

Газарзүй, Хүн ам

Тайланд нь Энэтхэг-Хятадын хойгт оршдог ба Мьянмар, Лаос, Камбож, Малайз гэсэн дөрвөн улстай 4863км урт зурвасаар хиллэдэг, далайд гарцтай 513 мянган км² газар нутаг, 65 сая хүн ам бүхий бүрэн эрхт, хэмжээт эрхт хаант засагтай вант улс юм. Тайланд нь газар нутгаараа дэлхийд 50-р байранд, хүн амаараа 20-р байранд орно. Хүн амын 80% нь Тайланд, 10% нь Хятад, 3% нь Малайз, үлдсэн 7% нь бусад жижиг үндэстэн, ястнууд эзэлдэг.

Улс төр

1932 оноос эхлэн Тайландын хаан нь хэмжээт эрхтэй



болсон. 1932 оноос эхлэн 20 удаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Тайландад төрийн эргэлт олон удаа болдогоороо алдартай ба 1932-2020 он хүртэлх 88 жилийн 66 жилд нь цэргийн эрхтэн төрийн өндөр албан тушаалд байсан, байсаар байна. Хамгийн сүүлийн удаа 2014 онд цэргийн эргэлт гарч, одоогийн ерөнхий сайд Прают Чан-Оча томилогдсон. Тайландын намууд тийм ч урт түүхтэй биш. 1992-2006 онд хоёр намын тогтолцоотой байсан. 2000 оноос хойш сонгуульд Тайландын төлөө нам болон Ардчилсан нам хоёр голчлон иргэдийн санал авч байсан ч сүүлийн үед 2017 оны шинэчилсэн Үндсэн хуулийн хүрээнд нэг нам олонх болж чадахгүй болж, олон намын тогтолцоотой болсон байдаг.

Хамгийн сүүлд Үндсэн хууль батлагдсанаас хойш хууль тогтоогчид, олон нийт болон өргөдөл гаргагчид дор хаяж дөрвөн удаа хуульд өөрчлөлт оруулахыг хүссэн. Мөн 2021 оны 11-р сард Тайландын парламент хуралдаж, өөрчлөлт оруулахаар санал хураалт явууллаа. Өмнө нь 2017 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр цэрэг татлагад өөрчлөлт оруулах уриалга гарсан ба үүнийг ардчилсан бус гэж үзсэн ардчиллын төлөө тэмцэгчид цэргээс томилогдсон Сенатыг татан буулгахыг дахин шаардаж байв.

2023 оны Ерөнхий сонгууль

Тайланд улсын Улсын Их Хурал нь 2 танхимаас бүрддэг ба нэг нь 500 гишүүнтэй Төлөөлөгчийн танхим болон хоёр дахь нь 250 гишүүнтэй Сенат юм. Сенатийн гишүүдийг ерөнхий сайд шууд томилдог ба 500 төлөөлөгчийг

сонгуулийн холимог гишүүдийн хуваарилалтын системийг (ММА) ашигладаг ба нэг тойргийн жижиг мандаттай плуралит болон пропорционал тогтолцоогоор сонгодог. Өмнө нь эдгээр 500 төлөөлөгчийн 350-ийг мандатаар 150-ийг намыг жагсаалтаар сонгодог байсан бол 2017 онд Улс төрийн намын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, эдгээр 500 төлөөлөгчийн 400 гишүүнийг мандатаар үлдсэн 100 гишүүнийг намын жагсаалтаар сонгодог болгосон.

Өмнөх сонгуулийн харьцуулалт:

	2007	2011	2019	2023
Саналын хуудасны тоо	2	2	1	2
Тойргийн суудлын тоо	400	375	350	400
Намын жагсаалт	80	125	150	100
Нэр дэвшүүлж буй намын тоо	39	40	81	70
Мандатаар нэр дэвшигчдийн тоо	3,894	2,422	10,792	4,710
Намын жагсаалтаар нэр дэвшүүлж буй намын тоо	31	44	77	67
Намын жагсаалтаар нэр дэвшиж буй нэр дэвшигчдийн тоо	1,260	1,410	2,810	1,899
Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо	45,092,955	46,921,682	51,239,638	51,287,045

Улс төрийн намууд гурав хүртэлх хүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх боломжтой. Төлөөлөгчийн танхимаас 25-аас дээш суудал авсан намууд Ерөнхий сайдад нэр дэвшигчээ өргөн мэдүүлэх боломжтой. Ерөнхий сайдаар сонгогдохын тулд нэр дэмшигч нь Сенатууд болон УИХ-ын гишүүний талаас илүү хувийг авах ёстой ба өөрөөр хэлбэл, хамгийн багадаа 376 /Төлөөлөгчийн танхимийн 500 гишүүн ба Сенатын 250 гишүүний талаас дээш/ гишүүний саналаар Ерөнхий сайд болно.

Сонгуулийн Ерөнхий хороо

Тайландын Сонгуулийн хороо (ECT) нь бие даасан байгууллага ба 2017 оны Үндсэн хуулийн дагуу сонгуулийг удирдах, хянах, зохион байгуулах бүрэн эрхтэй байгууллага юм. Сонгуулийн Ерөнхий хороог 7 комиссар удирдах ба хорооны Даргыг зөвхөн Тайланд улсын Хаан 7 жилийн хугацаатайгаар нэг удаа томилдог.





Сонгогчдын нэрсийн жагсаалт

Тайланд нь сонгогчдын автомат бүртгэлийн системийг ашигладаг ба Сонгуулийн өдөр 18 нас хүрч санал өгөх эрхтэй болж буй бүх сонгогчийн мэдээллийг автомат системээр боловсруулдаг. Сонгогчдын нэрс болон санал өгөх эрх үүссэн өрхийн гишүүдийн мэдээллийг дүүргийн бүртгэлийн байгуулагаас гаргадаг. Гэвч Үндсэн хуульд зааснаар зарим сонгогчдыг санал өгөхийг хориглосон байдаг. Эдгээр иргэдэд нь Буддын шашны лам нар, шинэхэн даяанч ба тахилч нар, сонгох эрхээ хасуулсан хүмүүс, тушаалаар цагдан хоригдож буй иргэд, өөрийн эрүүл ухаанаар санал өгөх боломжгүй иргэд байна.

СЕХ-ны мэдээллээр 2023 оны сонгуулиар СНЖ-д бүртгэгдсэн 52,287,045 сонгуулийн насны иргэд байна. Үүний 25,136,051 нь (48.1%) нь эрэгтэй, 27,150,994 (51.9%) нь эмэгтэйчүүд байна. Энэ удаад 18-22 насны 4 сая орчим анх удаа сонгууль өгөх залуучууд байсан ба тэд нийт сонгогчийн 7.67 хувийг эзэлж байна. Мөн насны бүлгээр "Gen Z" насныхан нийт сонгогчдын хамгийн их хувийг эзэлж байна.

Санал худалдан авалт

СЕХ нь санал худалдан авахтай тэмцэх зоргоор IT техник технологи ашиглан "Pineapple eyes" аппликейшн бүтээж иргэд, сонгогчдод танилцуулсан. Уг апп-аар иргэд өөрийн мэдээллийг нууцлан санал худалдан авч

байгаа талаар мэдээлэх боломжтой юм. Мөн санал худалдан авах талаар мэдээлэл, баримт өгсөн иргэдэд 100,000-аас 1 сая хүртэлх батт-аар шагнаж байсан нь маш үр дүнтэй байлаа.

Санхүүжилт

Улс төрийн намын тухай органик хуульд орсон зарим заалтууд нь улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийг зохицуулдаг. Тус хуулиар хандив, санхүүжилт, орлого зарлагын мэдээллийг нээлттэй тайлагнана гэсэн байдаг боловч хандив болон сонгуулийн сурталчилгааны бусад хугацааны зарлагын дээд хэмжээ гэж тогтоогоогүй байна.

Сурталчилгаа

Ажиглалтын явцад харахад нийт сонгуулийн хугацаанд маш тайван уур амьсгалтай байгааг олон ажиглагч нар тэмдэглэж байв. Нийт иргэд, сонгогчид нь сонгуулийн тогтолцоо, зохион байгуулалт болон нэр дэвшигч намын талаарх мэдээллээ тосгоны удирдагчийн өглөө бүрийн зар мэдээ, цахим орчин болон нэр дэвшигчдийн уулзалтаас авч байна. Сурталчилгааны хугацаанд ямар нэг зөрчил мэдээлэгдээгүй ба иргэд, оролцогч талууд нь мөн асуудал гараагүйг онцолж байв. Нэр дэвшигчдийн хооронд мөн хар ПР болон шударга бус өрсөлдөөн гараагүй байгааг мэдээллэж байв.

Урьдчилсан санал хураалт

Тайланд улсад сонгогчид нь хуулийн дагуу өөрийн тогтмол оршин суудаг бүртгэлдээ нутаг дэвсгэрт саналаа өгөх үүрэгтэй байдаг. Гэвч олон сая иргэн өөр хот, дүүрэгт ажилладаг ба шилжилт хөдөлгөөн хийлгэх нь амар биш, тухайн иргэн заавал өөрийн нэр дээр үл хөдлөх хөрөнгөтэй байх шаардлагатай тул олон иргэн санал авах өдөр өөрийн харьяа дүүрэг, аймагт очих шаардлагатай болдог. Тэгвэл СЕХ-оос санал авах өдрөөс 45-35 хоногийн хооронд иргэд урьдчилсан санал хураалтад цахимаар бүртгүүлж, санал авах өдрөөс 7 хоногийн өмнө урьдчилсан санал хураалтад оролцож, заасан санал авах байранд очиж биеэр саналаа өгдөг. 2023 оны сонгуульд 2,350,969 сонгогч урьдчилсан санал өгөхөөр бүртгүүлсэн байна.

Сонгогчдын Боловсрол

Тус улсын иргэд нь улс төр, сонгуулийн маш ээдрээтэй жилүүдийг туулсантай холбоотой юу, эсвэл тухайн улсын ардчиллын боловсрол, сонгогчдын боловсролын бодлого шийдвэр нь оновчтой байсан уу? Нийт сонгогч нь маш хариуцлагатай, өөрсдийн эрх болон үүргийг маш сайн ухамсарласан мэт санагдав. Оюутан залуус өөрсдийн санаачилгаар "WEwatch" гэх үндэсний хэмжээнд дотоодын ажиглалт зохион байгуулдаг ТББ-д бүртгүүлж, өөрсдийн харьяа санал авах байрыг сайн дураараа ажиглах, авсан мэдээлэл, ажиглалтын тайлангаа өөрсдийн хүслээр илгээж, танилцуулж байв. Маш олон сайн дурын байгууллага, бүлэг иргэд сонгуулийг ажиглах, түүнээс гадна зөв зүйтэй мэдээлэл олгох, сонгогчдын боловсрол өгөх ажлыг сайн дураараа хийж байна. Мөн сонгогчид нь сонгууль, шийдвэр гаргах түвшинд оролцох асуудалд хойрго хандах бус харин ч идэвхтэй, итгэл дүүрэн, хүлээж байв.

Сонгуулийн дүн

Энэ удаагийн сонгуулийн ирц хамгийн их буюу 75.22% байв. Хэдий маш халуун болон зарим хэсэгт хүчтэй бороотой байсан ч иргэд маш идэвхтэй саналаа өгч байв. Гэвч нэг том асуудал нь сонгуулийн дүнгийн нэгтгэл байв. Сонгуулийн хуулиар СЕХ нь санал авах өдрөөс


хойш 5 хоногт анхны сонгуулийн дүнгийн нэгтгэлийг зарлах ёстой. Өмнө нь "ЕСТ" апп-аар дүнг түргэн нэгтгэн харуулдаг байсан ч үүнийг 2019 онд халсан байна. Учир нь тус жил мэдээлэл нь солигдох, буруу ташаа тоон дүн нийтлэгдэх гэх мэт олон асуудал гарч, нийт иргэд олон нийтийн дунд итгэхгүй байх, буруушаах асуудлыг нэмэгдүүлсэн байна. Харин энэ жил шууд дамжуулж дүнг мэдээлэхгүй ба хяналтын тооллого зарим хэсэгт хийгдэж үүнийг дамжуулж байлаа. Санал авах байранд сонгуулийн дүнг гаргахад иргэний нийгэм, иргэд, оюутан залуус гэх мэт сонгогчид сайн дураараа оролцож, хамтран хяналтын тооллого хийж байлаа. Харин санал авах байрнуудаас ирсэн мэдээллийг нэгтгэх ажил нь хаалттай явагддаг ба үүнд ямар ч ажиглагч, хэвлэл мэдээллийг оролцуулдаггүй байна.

Тус улсын Засгийн газрыг тэргүүлж байсан Таксин Чинаватын охин Фетонг Тхан Чинаватыг Ерөнхий сайдын хувиар нэр дэвшүүлээд байгаа сөрөг хүчний "Тайландын төлөө" нам олонхын санал авч магадгүй боловч нөгөө талаараа залуусын дунд ихээхэн нэр хүндтэй "Ирээдүйн нам"-ыг татан буулгаж байгуулсан "Урагшаа хөдөлгөөн" гэх нэртэй улс төрийн нэгдлийн улмаас сонгуульд итгэл төгс ялахад амаргүй байна гэж үзэж байв. Тайландын Засгийн газрын одоогийн тэргүүн Прают Чан-Оча энэ удаад "Тайланд үндэстний нэгдэл" намаас нэр дэвшлээ.

Энэхүү таамаглалын дагуу "Урагшаа хөдөлгөөн" нам нь 500-гаас 151 суудал авч Их Хуралд хамгийн их суудалтай нам боллоо. Харин тус намын дарга шинэчлэлийг бий болгохын тулд 8 улс тарийн нам нэгдэж, хамтран ажиллахаар тохиролцсон талаар мэдэгдэж, хамтран ажиллан санамж бичигт бүгд гарын үсэг зурлаа. Энэхүү нэгдэл нь нийт 312 төлөөлөгчийг нэгтгэсэн ч Ерөнхий сайдыг томилоход шаардлагатай 376 санал хүрэхгүй байгааг онцлов. Гэвч Ерөнхий сайдыг сонгох УИХ-ын хуралдаанаар 324 санал авснаар ЕС-д томилогдож чадаагүй. Дараагийн хуралдаан тус намын дарга, ЕС-д нэр дэвшигчийг авлига ашиг сонирхлын хэргээр шалгаж эхлэв. Энэ нь түүний олон жилийн өмнө нь эзэмшиж байсан Хэвлэл, мэдээллийн байгууллагын хувьцаатай холбоотой байсан ба үүнийг хэрэгсэхгүй, үндсэлэлгүй болгосон ч дахин түүнийг дэмжиж санал өгөх төлөөлөгчдийн тоо цөөрч улмаар Pheu Thai намаас ЕС-д нэр дэвшсэн Srettha Tavishin ЕС-аар томилогдов.





A vertical purple bar with a geometric pattern of overlapping triangles. The number 10 is prominently displayed in white at the bottom of the bar.

10

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ КЛУБ

Номын баярын сондгой асар буюу
сонгуулийн ерөнхий хороо анх удаа
“гудамжинд” гарав

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН

55

НОМЫН БАЯРААС ХИЙСЭН СУРВАЛЖИЛГА

НОМЫН БАЯРЫН СОНДГОЙ АСАР БУЮУ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО АНХ УДАА “ГУДАМЖИНД” ГАРАВ

С.УЯНГА

“Зууны мэдээ” сонины сэтгүүлч

Жил бүрийн хавар, намрыг чимдэг Үндэсний номын баяр хүүхэд багачуудаас эхлээд хөгшид, залуусыг булаар нь төв талбайд “уяж” чаддаг. Тэгвэл энэ жилийн номын баяр ч сонин ихтэй, содон сайхнаар дүүрэн болж өнгөрөв. Ном, сонин, сэтгүүл далбайтал үүрсэн, дүүрсэн, торлосон, сугавчилсан олон өнгө гурван өдрийн турш сүлэлдсэн нь Монголчууд, тэр дундаа залуус хүүхдүүд эрдэм мэдлэгт хэрхэн шимтэн дурлаж буйн тод илэрхийлэл юм. Номын баярын

сонин сайхан өнөөдөр ч хуучраагүй, улам бүр хачир нэмэгдэн баяжсаар дараагийн баяр хүртэл ам дамжин яригддаг даа.

Тэгвэл уламжлал ёсоор хавар, намар хоёронтоо зохион байгуулагдсан Үндэсний номын баярт Сонгуулийн ерөнхий хороо алгасалгүй оролцож “Сонгуулийн боловсрол” асар ажиллуулав. Энэхүү асарт санал авах байрны жишиг загвар, Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай

хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан онцлог зохицуулалт, УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд хэрэглэх саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарын загвар, “Сонгогчийн ном” гарын авлага, “Сонгуулийн боловсрол” сэтгүүл, “Монгол Улсын Сонгуулийн түүхэн товчоон”, 30 жилийн дүн мэдээлэл зэргийг үзүүлж, харуулах үүх түүх, шинэ содон зүйлээр баялаг байлаа.



НОМЫН БАЯРЫН “ЭВЭРТЭЙ ТУУЛАЙ”

Номын баяр дээр өөрсдийн өнгө төрхийг тодотгох гэсэн олон асар эгнэн байрладаг жишиг загвар 33 жил өөрчлөгдөөгүй. Энэ жил ч зохион байгуулалт өөрчлөгдсөнгүй. Харин тэр дунд урьд өмнө үзэгдэж харагдаагүй нэгэн сондгой асар шинээр нэмэгдсэн нь сонгуулийн төв байгууллага байв. Номын баярын нэг онцлогийг харуулдаг дан ном худалдаалах бус иргэдэд мэдээлэл өгөх, сонирхолтой зүйлсийг туршиж үзэх агуулгад төрийн байгууллага, тэр дундаа сонгуулийн төв байгууллага



нэгдсэнийг гайхсан хүн ч таарч байв. Сонжиж харвал номын баяр дундуур санал авах жишиг байрыг бодитоор нь ажиллуулж, олон нийтийн хэлдгээр сонгуулийн хар машиныг талбай дээр аваад ирчихсэн байсан нь хэн бүхэнд ёстой л “эвэртэй туулай” шиг харагдсан хэрэг. Ном сугавчилсан хүмүүс сонгуульд санал өгөөд гарч ирээд байхаар арга ч үгүй байх. Тиймдээ ч сонгуулийн хорооны асарыг шохоорхон зорьж очсон иргэдэд Сонгуулийн боловсрол, хариуцлагатай сонгогч гэж хэн болох, сонгуульд идэвхтэй оролцохын ач холбогдлыг Сонгуулийн ерөнхий хорооны ажилтнууд болоод сэтгүүлчид, салбарын экспертүүд тал талаас нь тайлбарлан таниулж байсан нь бас нэг шинэ жишиг боллоо. Энэ үеэр Сонгуулийн ерөнхий хорооны хэвлэлийн төлөөлөгч З.Бадмаараг “1992 оноос хойш болсон бүх сонгуультай холбоотой дүн, статистик мэдээллийг баар кодтой болгон цахимд байршуулж, дата мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн. Иргэд бүхий л цаг үед мэдээллийг

www.m-election.mn хуудсаар авах боломжтой. Мөн санал авах байрны жишиг асрыг байршуулснаар сонгогчид мэдлэг мэдээлэлтэй сонгуульд оролцохын ач холбогдол, санал өгөхдөө гаргадаг нийтлэг алдаа, эрх зүйн боломж бололцоог бодитоор харах боломжтой болж байна. Иргэд зөвхөн сонгууль дөхөхөөр л энэ асуудлыг ярьдаг биш байнга мэдлэг мэдээлэлтэй байж, тодорхой хэмжээний эрх, үүргээ мэддэг байх хэрэгтэй. Сонгуульд оролцох нь маш чухал, таны ирээдүй танаас шалтгаална гэдгийг л ойлгох хэрэгтэй. Энэхүү үйл ажиллагаанд анх удаа сонгууль өгөх залуус ихээхэн сонирхон ирж байна. Залуус ч гэлтгүй бүх хүн эрх зүйн тодорхой мэдлэгтэй байснаар сонгогдсон хүмүүст ч шаардлагаа тавьж чаддаг болно” гэсэн юм.

Сонгуулийн ерөнхий хороо “Сонгогчийн ном” гарын авлага, “Сонгуулийн боловсрол” сэтгүүл, “Монгол Улсын Сонгуулийн түүхэн товчоон-30”, УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн



дүнгийн эмхэтгэлүүд (1992-2021 он) зэрэг ном, товхимлыг түгээж, санал авах байрны жишиг загварыг ажиллуулж, сонгуулийн автоматжуулсан системийг иргэд, олон нийтэд танилцуулан туршиж, сорьж үзэх нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа. Өөрөөр хэлбэл, мянган удаа сонссоноос нэг удаа туршаад үзэх боломжийг олгож байгаа. Иргэд сонгуулийн талаар мэдлэг мэдээлэлтэй байж, тодорхой хэмжээний эрх, үүргээ мэддэг байх хэрэгтэй. Бид номын баярын үеэр 21 аймгийн хүүхдүүдэд “Сонгогчийн ном”, “Сонгуульд хэрхэн мэдлэг, мэдээлэлтэй оролцох вэ?”, “Би хариуцлагатай сонгогч” гарын авлага, брошур, номын хавчуургын дээжээс хандивлалаа гэсэн мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгсөн юм.

“Сонгогчдын боловсрол” төвийн захирал С.Оюунтуяа “Сонгогчдын боловсрол” төв “Оролцоно төлөөлнө” өдөрлөгөөр Үндэсний номын баярт анх удаа нэгдэж байна. Бид “Оролцоно төлөөлнө” амлалтын өдөрлөгөөрөө шийдвэр гаргах үйл явцад хүйсийн тэгш байдлыг хангахад залуучууд, сонгогчид юу хийх бололцоотой вэ? гэдгийг таниулах үйл ажиллагаануудыг зохион байгуулж байгаа юм. Залуучууд манай асрыг “хамгийн өнгөлөг, күүл асар байна” гэж үнэлсэнд том урам авлаа. Шийдвэр гаргах үйл явцад яагаад эмэгтэйчүүд оролцох ёстой вэ? гэдэг асуултад хариулт өгөх үүднээс өнөөдрийн бодит нөхцөл байдлыг тооны хэлээр үзүүлэхийг зорьсон. Манай асарт ирсэн хүмүүс өөрсдийн амьдардаг аймаг, дүүрэгт гарч байгаа бодлого, шийдвэрүүд хэний оролцоотой гардгийг эргэж харсан. Мөн манай сайн дурын ажилтнуудтай энэ чиглэлээр сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлж болно. Түүнчлэн бидний дунд жендэрийн ямар хэвшмэл ойлголтууд амь бөхтэй байгаа вэ? гэдгийг ярилцаж, түүнийг хэрхэн засаж залруулах тухай ярилцах



асраар зочилж хариуцлагатай, идэвхтэй сонгогч байх талаар мэдэж авлаа. Бид ангийнхнаа санал өгч үзэх үү гээд дуудчихсан хүлээж байна” гэлээ. Ийнхүү Сонгуулийн төв байгууллага анх удаа ард түмний дунд “гудамжинд” гарсан нь энэ. Лав сүүлийн 14-15 жил ийм нээлттэй байгаагүй гэдгийг хэвлэл мэдээллийнхэн ч, олон нийт ч мэднэ. Асуувал нэгэн дуугаар хариулах нь лав. Тэр тусмаа голдуу Төрийн ордон хавьцаа л харагддаг Сонгуулийн ерөнхий хорооны дарга удирдлагууд ч задгай асар майханд суучихсан орж гарсан хүмүүст мэдээлэл өгч “үйлчилж” харагдсан нь содон төрх байв. 33 жилийн түүхтэй Үндэсний номын баярт шинэ өнгө нэмж, сонгуулийн байгууллагын түүхэнд шинэ жишиг бий болгосон сондгой асар буюу сонгуулийн ерөнхий хороо анх удаа “гудамжинд” гарсан нь сайшаалтай биш үү.

болон өөрсдийн оролцоогоор нэгдэж байна. Тэгш оролцоо, тэгш боломж, тэнцүү төлөөллийн төлөө хариуцлагатай сонгогчийн амлалтад хүмүүс цахимаар болон гарын үсгээ зурж нэгдэж байна. Зөвхөн шийдвэр гаргах гэлтгүй бүх түвшний улс төр, нийгэм, соёлын амьдралд оролцож байгаа эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих аянд биечлэн болон цахимаар нэгдэж байна” гэж байлаа.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО АНХ УДАА АРД ТҮМНИЙ ДУНД ОРОВ

Иргэд сонгуулийн автоматжуулсан системийг гараар барьж, имэрч, “хазаж” үзэх боломж олголоо хэмээн ихээхэн сонирхож байлаа. Сонгууль болгоноор хар машин

хэмээн муучилдаг автоматжуулсан системийг дахин дахин шалгаж, туршиж, түншиж үзэж, эрсэн, эргэлзсэн зүйлээ нягталж үзлээ хэмээцгээж байв. Зарим нь задлаад шилэн хоргонд хийчихсэн хар машиныг хараад хаана нь “хүн” сууж байдаг юм бэ гэж хошигнох.

Мөн санал авах жишиг байраар хамгийн их зочилж буй нь оюутан залуус байсан. Тэд ирэх жилээс санал өгөх учраас өмнө нь танилцаж туршилтаар санал өгөхөөр ирцгээжээ. Их сургуулийн оюутан Б.Ивээлэн “Би санаандгүй явж байгаад санал өгөх байртай таарч туршилтаар санал өглөө. Их сонин юм байна. Анх удаа өгч байгаа болохоор саналын хуудсаа буруу тэмдэглээд автомат машин уншихгүй буцаасан. Тиймээс саналын хуудсан дээр хэдэн хүн тэмдэглэх зааврыг нь сайн уншихгүй бол нэг л тоо илүү юм уу дутуу тэмдэглэхэд машин уншихгүй буцаадаг юм байна. Санал маань хүчингүй болбол харамсалтай шүү дээ. Бас Сонгуулийн боловсрол





**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:

gecm@m-election.mn
(976) -51 262127

UHH.MN
СҮЛДЭГ ААНХААН